

Шилдэг борлуулалттай номын зохиогч
Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай

ХАЙР ЦОРЫН ГАНЦ ШИЙДЭЛ НЬ

Love
Is The Only
Solution



Хайр Цорын Танц Шийдэл нь

- Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай

Агуулга

Зохиогчийн намтар	3
Оршил: Хайр цорын ганц шийдэл нь	4
1 Дэлхий дахины өнөөгийн нөхцөл байдал	6
2 Байгаль орчин	12
3 Яагаад бид энэ дайн дажин, өвчин эмгэг, байгалийн гамшигт нэрвэгдэх болов?	18
4 Хүн төрөлхтний бүхий л асуудлын шийдэл нь ХАЙР юм	25
5 Дотоодын хийгээд Дэлхий дахины амар амгалангийн төлөөх бясалгал	41
6 Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн бүх Шашны болон Оюун санааны удирдагчид илгээсэн захидал	55
7 Дэлхийн бүх улс орны төр засгийн удирдагч, Засгийн газарт яаралтай хүргэх Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн захидал	81
8 Их Багшийн илгээсэн урмын үгс	120
9 Веган Дэлхийн төлөө залбираарай	127
Эшлэл	131

Зохиогчийн намтар

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай төв Ау Лакт (Вьетнамд) төржээ. Арван найман насандаа Англи руу сурахаар явж, дараа нь Франц, Германд очиж, тэндээ Улаан загалмайн нийгэмлэгт ажиллаж байхдаа герман эмчтэй гэр бүл болсон байна. Гэр бүл болоод хоёр жил аз жаргалтай амьдарсны дараа нөхрөөсөө зөвшөөрөл аван гэрлэлтээ цуцлуулж, хүүхэд ахуй насны мөрөөдлөө даган гэгээрлийг эрэлд гарчээ.

Ийнхүү Тэрбээр олон улс орноор бядан явах хүнд хэцүү даяанчлалын замыг эхлүүлсэн бөгөөд амьд Төгс Гэгээрсэн Их Багштай Хималайн ууланд учирснаар энэ аялал нь өндөрлөжээ. Их Багш Чин Хай дотоодын Гэрэл, Аялгууг уламжлан авч үүнийгээ хожим нь Арьяабалын Арга хэмээн нэрлэсэн байдаг. Хэсэг хугацаанд хичээнгүйлэн бясалган дадуулсны дараа Тэрбээр төгс гэгээрэлд хүрчээ. Чин сэтгэлтэй Үнэнийг эрэлхийлэгчдийн хүсэлтийн харгалзан Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай бясалгалын Арьяабалын Аргыг янз бүрийн үндэс угсаа, шашин шүтлэг, соёл уламжлалтай хүмүүст зааж сургадаг билээ. Түүний хайр энэрэл, энх амгалангийн сургаал нь дэлхийн хүмүүст сүнсний чөлөөлөлт, итгэл найдварыг бэлэглэн Үнэн, Зөв, Ариуныг дээдлэн амьдрахыг сануулж байдаг.

Оршил

Хайр цорын ганц шийдэл нь

“Амьдрал хийгээд бүхий л ертөнцийн хамгийн аугаа зүйл нь хайр билээ. Гэвч энэ цаг үед ихэнх хүмүүст хайр дутмаг байна. Хүмүүс урьд урьдаасаа илүү хайраар дүүрэн байх хэрэгтэй. Бид хөршүүдээ, амьтдыг, хүрээлэн буй байгаль орчноо, тэр бүү хэл дайснуудаа ч хайрлах ёстой, ингэж байж л хямралыг давж, энх амгалан амьдарна. Хайр үйлдлээр илрэх ёстой. Хайрыг ярих биш, харин үйлдлээрээ харуулах ёстой. Веган (ургамал хоолтон) болж, сайныг үйлдэн, байгаль орчноо хамгаалаарай.”¹

“Би хүмүүсийг хайраа үйлдлээрээ харуулаасай гэж боддог, дэлхийн төлөө, үр хүүхдийнхээ төлөө, бүхий л төрөлтнүүдийн төлөө зөвхөн 1 хувийн илүүхэн хайр зориулж чадвал амьтны мах идэх, бусад харгислал шингэсэн бүтээгдэхүүнийг амтлах, хэрэглэх хүслээсээ татгалзаж чадна. Зөвхөн гэр бүлийн гишүүдээ гэх хайраас гадна бид хайрыг илүү өргөн утгаар нь харж хэрэгжүүлэх ёстой. Бүхий л хайр нандин учраас гэр бүлээ гэх хайраа мэдээж хадгалж яваарай. Ямар ч хайр биднийг, бидний хайртай хүмүүсийг, эргэн тойронд маань байгаа бүхнийг хамгаалдаг эерэг сайхан эрч хүчийг ялгаруулж байдаг.

Ийнхүү хүн бүр эргэн тойрондоо урьдахаасаа арай илүү хайр түгээсээр, хайраа улам бүр өргөжүүлсээр, гэр бүлийн хайрын хүрээллээ бага багаар тэлсээр байвал бидний амьдралд хамгийн их аюул занал үүсгэж байгаа асуудлыг шийдэхэд шаардлагатай тэр хайрын хүчийг 100 хувь бүрдүүлж чадна.”²

-Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай

1 Дэлхий дахины өнөөгийн нөхцөл байдал

“Энэ дэлхий яагаад сайжрахгүй байна вэ?” гэж би бодлоо. Яагаад миний хүссэн шиг өөрчлөгдөхгүй байна вэ л гэх гэсэн юм. Байдал хангалттай сайжрахгүй байна. Диваажинтай адилгүй байна, төрөлтөн нэг бүрд амар амгалан алга. Өнөө хүртэл энэ дэлхий эмх замбараагүй хэвээрээ л байна. Зөвхөн цар тахал гэлтгүй, зарагдаагүй гэсэн шалтгаанаар амьтад хэдэн мянгаараа үхэж үрэгдэж байна. Тэд хэдэн зуун мянгаар нь алж байна. Гахай, үхэр, тахиа, булгыг үй олноор нь хөнөөж байна. Дэлхий тэр аяараа хомсдолд оржээ. Халдвар тархсаны улмаас хүмүүс ажлаа хийж чадахгүй, орлого муу байгаа ч төлбөр зардал гардаг хэвээрээ. Америкчуудын нийт өр 30 их наяд доллар хүрсэн гэж би сонслоо. Аль хэдийнээ олон их наядад хүрчээ.

Эбола вирус дахин гарч ирлээ. Гэхдээ байдал одоохондоо арай л гайгүй байна. Тахианы салмонела вирус илэрсэн гэхчлэн олон муу мэдээ байна. Улирлын чанартай ханиад томуу үргэлжлэн гарсаар байна. Өвчин тахал ахин дахин гарч, зарим нэг нь бүр

үхлийн аюултай, хүний биеийг тавгүйтүүлж элдэв хор холбогдол учруулж байна. Түүнээс гадна SARS, MERS гэх мэтийн өмнө нь гарч байсан өвчин тахал дэлхийн хаа нэгтээ илэрсээр л байна. КОВИД-19 шиг хурдацтай тархдаггүй ч, ямар нэгэн хэмжээгээр тархсан хэвээрээ байна.

Өнөө үед КОВИД-19 бүхний анхаарлын төвд байна. Хорт хавдартай өвчтөнүүд олон байгаа ч тэднийг анхаарахгүй байна гэж хүмүүс гомдоллож, энэ тухай сонинд хэвлэгдсэн байсан. Сүрьеэ өвчнийг хайхрахгүй байна, хүмхээ гэх мэт бусад олон архаг, аюултай өвчтэй олон хүн байгаа ч КОВИД-19-ийн нөхцөл байдлаас болж хайхралгүй орхиж байна. Хөл хорьж, эмнэлгүүд дүүрч, халдвар авагсдын тоо нэмэгдэн нөхцөл байдал улам бүр ноцтой болсоор байна. Олон өвчтөнийг, ялангуяа ахмад настнуудыг сайн асарч чадахгүй, тэд нас эцэслэж байна.

Энэ цар тахлын улмаас хүмүүс үхэж үрэгдэж буй ч, өөр бусад шалтгаанууд байна. Өмнө нь гарч байсан цар тахлууд одоо ч дэгдсээр. Хажуугаар нь олон газар үер, аадар бороо, хөрсний гулсалт, царцааны нүүдэлд нэрвэгдэж, зөгийний тоо толгой цөөрч, хаа сайгүй ган гачиг болж, тариаланчид хүнд байдалд орсоор байна. Хэн ч тэдэнд тусалж чадахгүй байна. Дэлхийн нөхцөл байдал үнэхээр түгшүүртэй байгаа

учраас хүмүүс энэ бүхний улмаас хүнсний хомсдол үүсэх вий гэж эмээж байна.

Хүмүүс сэтгэц мэдрэлийн дарамтад орж байна. Нөхцөл байдлаас болж, магадгүй эсвэл вирус тархинд нь нөлөөлснөөс болсон уу эмч нар эрүүл саруул ухаанаар сэтгэж чадахгүйд хүрч, зарим нь амиа хорлосон. Ийм л зүйл болж байна. Үнэхээрийн үзэсгэлэнтэй нэгэн америк эмч эмэгтэй ийм шалтгааны улмаас амиа хорлосныг би харсан. Ийм олон тохиолдол байна. Халдвар авсны улмаас олон эмч нар, эмнэлгийн ажилтнууд, сувилагчид амь насаа алдлаа. Яагаад гэвэл цар тахлын эхэн үед ямар ч бэлтгэлгүй, өөрсдийгөө хамгаалах багаж хэрэгсэл хангалтгүй байсан учраас тэд амь насаа алдсан. Төсөөлөөд үз дээ, ямар их баатарлаг хүмүүс вэ.

Англи Улсад жишээ нь, тэтгэвэртээ гарсан эмч сувилагч нар эргээд ажилдаа орсон. Яагаад гэвэл тэдний тусламж хэрэгтэй байсан учраас ирсэн. Эмнэлгээс нь дуудсан учраас тэд буцаж ирээд ажиллаж байхдаа өөрсдийгөө золиослон амиа алдсан. Тэднээс олон хүн амь насаа алдсан. Ийм л явдал болж байна! Төсөөлөөд бод доо. Маш аймшигтай! Тэд таны гэр бүлийн хүмүүс байсан бол танд ямар санагдах вэ? Бүх насаараа хичээнгүйлэн шаргуу хөдөлмөрлөсний эцэст тэд үлдсэн жаахан

амьдралаа жаргаж өнгөрөөх байсан атал, өөрсдийгөө золиосолж, амь насаа алдаж байна! Надад бол энэ шударга бус санагдаж байна.³

Одоогийн энэ цаг үе бол асар том цэвэрлэгээний цаг үе. Үүнийг даван туулаа ч араас нь өөр сорилтууд гарч ирнэ. Зөвхөн энэ ч биш, энэ цаг үед олон аюул гарч ирнэ. Эбола байна, тахианы аж ахуйгаас салмонела илэрлээ, иймэрхүү зүйл өч төчнөөнөөрөө гарч ирнэ. Түүнээс гадна булганы гаралтай өвчин байна. Хүмүүс арьсыг нь хуулаад өмсдөг булгыг мэднэ биз дээ? Европын зарим улс орон, Нидерландад билүү дээ, халдвар дамжуулна гэж эмээн олон мянган булгыг устгасан байна. Энэ олон амьтны амийг хөнөөгөөд нэмэргүй, өөрсдийнхөө амьдралын хэв маягийг өөрчлөхгүй бол асуудал шийдэгдэхгүй.

Ой модыг тайрч огтлон зэрлэг амьтдад амьдрах орчин үлдээгээгүй учраас тэд бидний амьдрах орчин хүрээлэл руу улам ойртож өвчин халдаах эрсдэл байсаар л байх байна. Тэгээд халдвар нэгээс нөгөө лүү үсэрч, дэлхий даяараа дахин асуудалд орно. Хэрэв амар амгаланг хүсэж байгаа бол бид ердөө л амьтдыг тайван орхих ёстой. Ингээд л болоо. Тун энгийн. Би илүү олон зүйл хэлэхгүй, яагаад гэвэл энэ бүхэн бодит үнэн гэдгийг хүн бүхэн мэдэж байгаа учраас үүнээс илүүг би хэлж чадахгүй.⁴

2 Байгаль орчин

Дэлхий дахинд бүртгэгдсэн уур амьсгалын хэт их дулаарлын үр дагавар тогтмол нэмэгдсээр байгааг та нарын ихэнх нь мэдэж байгаа учраас би АНУ болон дэлхийн цөөхөн баримтыг л энд дурдъя.

Арктик болон Хойд Туйлын мөс асар хурдтайгаар хайлж байгаа учраас эрдэмтэд гурваас зургаахан жилийн дараа бид мөсгүй зуныг үзнэ гэж тооцоолсон байна. Хэрэв тэгвэл энэ нь сүүлийн сая жилийн анхны тохиолдол болох юм! Түүнээс гадна агаар мандлын дулаарлын улмаас Гринландын мөс өдөр бүр 85 сая тонноор багасаж, энэ хэмжээ жил бүр долоон хувиар хурдсаж байна. Баруун Антарктидын мөсөн бүрхүүл хайлсаар байна. Үүний улмаас далайн төвшин 3.3 метрээр нэмэгдэнэ гэсэн тооцоо гарч байгаа бөгөөд Нью Йорк, Вашингтон ДС болон Сан Франциско хотууд усанд автах аюул заналхийлж байна. Хэрвээ Антарктид, Гринландын бүх мөсөн давхарга хайлбал далайн төвшин 70 гаруй метрээр дээшилж, дэлхий дээрх ихэнх амьд оршихуй мөхөх аюултай.

Дэлхийн мөсөн голууд судлаачдын тооцоолсноос илүү хурдан ширгэж, гол мөрөн, нуур цөөрмүүд хатаж устан үр тариагаа услах үсгүй болж, улмаар олон тэрбум хүн усны хомсдолоос үүдэлтэй хүнсний дутагдалд орох аюул нүүрлээд байна. Далайн усны төвшин нэмэгдсээр биднийг ярьж байх яг энэ мөчид хүртэл арлууд живсээр байна, Тувалу, Тонга зэрэг 40 гаруй арлын орнууд бүх улс орноороо хаа нэг тийшээ дүрвэн нүүх төлөвлөгөө гаргаж байна. Тэд аль хэдийн 20 саяыг давчихсан уур амьсгалын дүрвэгсдийн эгнээнд хүчээр орж байна. Олон Улсын Шилжилт Хөдөлгөөний Байгууллагын мэдээлж байгаагаар 2050 он гэхэд уур амьсгалаас үүдэлтэй дүрвэгсдийн тоо 200 саяд хүрнэ.

АНУ-ын Жоржиа муж дахь Технологийн хүрээлэнгийн судлаачдын мэдэгдсэнээр хамгийн их хор хөнөөлтэй буюу 4, 5 дугаар зэрэглэлийн хар салхины тоо дэлхий хэмжээнд сүүлийн 35 жилд хоёр дахин нэмэгдсэн байна. 5 дугаар зэрэглэлийн хар салхи том хотуудад маш ноцтой хохирол учруулдаг. Энэ салхины эрч хүч болон үргэлжлэх хугацаа 1970 оноос хойш 75 хувиар нэмэгдсэн байна. Үр нөлөө нь өнөөг хүртэл мэдрэгдэж, одоо ч нүдэнд харагдсаар байгаа 2005 оны Катрина хар салхинд, ялангуяа Нью Орлеанчууд хамгийн хүндээр нэрвэгдэж, хүмүүс өнөөдрийг хүртэл

сүйдсэн амьдрал, орон гэрээ сэргээж амжаагүй л байна. Америкийн ард иргэд ийм гамшиг зовлонг туулж байгааг үзээд би үнэхээр их харамсаж, өрөвдөж байна.

Дэлхийн дулаарлаас үүдэлтэй цох хорхойн нүүдэл АНУ-ын Року уулст нэг сая орчим акрын нарсан ойг сүйтгэсэн байна. Үүнтэй адил төстэй гамшиг Канадад бас нүүрлэж байна, гэхдээ цаг хугацаа давчуу байгаа учраас би бүгдийг нь мэдээлэх боломжгүй, зөвхөн АНУ-ын мэдээллийг дурдаж байна.

Монтана мужийн Глэйшиэр Цэцэрлэгт хүрээлэнгийн алдарт мөсөн голууд арван жилийн дотор алга болно гэсэн тооцоо гарчээ. Далай судлалын Скриппс хүрээлэнгийн саяхан гаргасан судалгааны дүнгээс үзэхэд баруун долоон мужийг усаар хангадаг Колорадо мөрөн хатаж ширгэж байгаа аж. Алдартай мөрөн шүү дээ. АНУ-ын баруун бүс нутагт ийнхүү уул нуруудын мөнх цас, асар их хэмжээний усны нөөц урсаж алга болж байгаа нь яваандаа аймшигтай ган гачиг нүүрлэх аюулд хүргэнэ гэж тооцоолжээ.

АНУ-ын Хойд Каролина мужид 500 жилийн өмнөхтэй харьцуулахад 20-р зуунд далайн усны төвшин гурав дахин илүү хурдтай нэмэгджээ. АНУ-ын Үндэсний далай

судлал болон агаар мандал судлалын төвөөс түүхэнд анх удаа 2008 онд дараалсан зургаан циклон шуурга АНУ-ын эх газрыг дайрсныг онцолжээ. Хойд Атлантын далай болон Энэтхэгийн далай нь хамгийн хүчтэй далайн шуурга дэгддэг газар билээ.

Байгаль орчинд ийм их гай гамшиг, сүйрэл хохирол учруулж байгаа гол шалтгаан нь юу вэ гэж та асууж магадгүй? Хачирхалтай нь үүний шалтгаан нь нүүрс олборлолт, эсвэл машин, онгоц, гал тэрэг, эсвэл завь, усан онгоц биш, харин мал аж ахуйн үйлдвэрээс голчлон ялгардаг хорт метан хий юм.⁵

3 Яагаад бид энэ дайн дажин, өвчин эмгэг, байгалийн гамшигт нэрвэгдэх болов?

Ертөнцийн хуулийг дээдэл

Бурхан, ертөнцөд мөрдөх хуулийг бүтээхдээ зайлшгүй дагах ёстой хэдэн дүрмийг тогтоосон байна. Энэ нь яг л зам, тээврийн хөдөлгөөнийг улам таатай болгохын тулд, ард иргэд, явган зорчигч, жолооч нарыг хамгаалахын тулд замын хөдөлгөөний үрсгалыг зохицуулахын тулд нийтээрээ дагаж мөрдөх дүрэмтэй байдагтай адил юм. Хэрэв энэ дүрмийн дагуу замын хөдөлгөөнд оролцвол осол гарахгүй, хэрвээ зөрчвөл асуудал үүснэ. Амь насаа алдаж мэднэ, гэмтэж бэртэнэ, тэгвэл өөрснөө төдийгүй гэр бүл, хамаатан садан, найз нараа зовооно.

Бурхан энэ дэлхийн зовлонд буруугүй. Бурхан биднийг сорьж шалгаагүй. Бурхан бидний итгэл, чин сэтгэл, зориуллыг сорих гэж бэрхшээл, зовлон шаналлыг илгээдэггүй. Огт үгүй. Бид өөрсдөө л бий болгодог. Тийм учраас, “Юу тарина, түүнийгээ л хураана.” гэж хэлдэг. Хаа сайгүй хүмүүс өөрт тохиолдсон элдэв зүйлд

Бурханыг буруутгаж байхыг би сонссон, гэтэл энэ нь яг л согтууруулах ундаа уусан үедээ жолоо барьж яваад эсвэл баруун эгнээг барьж явах байтал зүүн эгнээгээр явж байгаад осол хийчхээд замын хөдөлгөөний дүрмийг буруутгаж байгаатай адил юм. Энэ бол Засгийн газрын буруу биш, энэ таны буруу. Замын хөдөлгөөний дүрэмд согтууруулах ундаа уусан үедээ жолоо барьж болохгүй гэдгийг, зүүн эгнээгээр биш, баруун эгнээг барьж явах ёстой гэдгийг урьдчилан заасан байдаг шүү дээ.

Үүнтэй адилаар, Бурханы хуулийг дагахгүй бол асуудал үүснэ. Тэр хуульд амь хороож болохгүй гэж заасан байдаг. Гэтэл бидний өвөг дээдэс хэдэн зууны турш юу хийж ирснийг хар, өнөөг хүртэл бидний зарим ах дүүс юу хийж байгааг хар л даа. Бүр Бурханы нэрийг, Есүсийн нэрийг барьж нэг нэгнийхээ эсрэг дайн дэгдээдэг нь туйлын харамсалтай. Энэ бол Бурханы таалал биш, Есүс Христ ч үүнийг хүсээгүй. Нэг нь бусдыгаа хөнөөж, бусад нь нэгийгээ хороож, хүүхдүүд нь түүний хүүхдүүдийг хөнөөж, түүний хүүхдүүд буцаад өшөөгөө авч аллага үйлдэнэ, энэ үйлийн үр ийнхүү мөнх үргэлжилдэг!

Дайн маш их гамшиг дагуулдаг. Дайн улс орны эдийн засгийг сулруулж, хүмүүсийн хүч чадлыг сорж, тэдний ёс суртахуун, итгэл бишрэлийг доройтуулдаг учраас хүмүүс

ахиад л Бурханыг буруутгана. Тэд, “Бурхан байдаг юм бол Тэр яагаад дайн гарахыг зөвшөөрч байна вэ? Тэр яагаад хүмүүст нэг нэгнээ хөнөөхийг зөвшөөрдөг юм бэ?” гэх мэтчилэн олон зүйлд буруутгана.

Өнөө үед манай дэлхийд уур амьсгалын өөрчлөлт, өлсгөлөн, элдэв төрлийн өвчин гээд олон зовлон бэрхшээл учирч байна. Итгэл бишрэл муутай зарим хүн дахиад л Бурханыг буруутгана. Миний лекц уншсан газар бүрд хүмүүс надаас, “Бурхан гэж байдаг юм бол яагаад энэ, тэр гамшиг болсон юм бэ?” гэж их асуудаг. Энэ хүмүүс Бурхан энэ бүх зовлонг тариагүй, бид өөрсдөө энэ бүх асуудлыг үүсгэсэн гэдгийг санах ёстой. Жишээлбэл, хэд хэдэн улс атомын бөмбөг, үстөрөгчийн бөмбөгийг байнга түршиж байгаагаас болж агаар мандлын тогтвортой байдал алдагдаж, улмаар дэлхийг оршин тогтноулж ирсэн тэнцвэр алдагдаж байна. Тэд бөмбөгийг агаар мандал руу, эсвэл далайд тэсэлж дэлбэлэхэд ямар ч асуудал үүсэхгүй гэж боддог. Харамсалтай нь асуудал үүсдэг, учир нь ертөнц олон төрлийн түмэн бодисоос бүрддэг бөгөөд тэдгээрийн зарим нь бидэнд үзэгддэг, зарим нь үзэгддэггүй. Үл үзэгдэх тэр бодисуудыг үймүүлснээрээ бид ертөнцийн тогтвортой байдлыг алдагдуулж, байгалийн жам ёсны хөгжил хувьсалд хөндлөнгийн саад учруулдаг.

Жишээлбэл, та цонх, хаалга, бас хэдэн өрөөтэй байшин барилаа гэж бодъё. Гэтэл хэрвээ байшингийн нэг булан эвдэрвэл өрөөний температур өөрчлөгдөнө. Хэдийгээр зуны улирал ч гэлээ, онгойсон нүхийг буцаагаад бөглөхгүй бол зуны шөнө заримдаа хүйтрэх, эсвэл бороо орох тохиолдол байдаг учраас та даарна.⁶

Өөрсдийн Баатарлаг Нигүүлсэнгүй Мөн чанараа Хамгаал

Бид хүнлэг чанараа, хүний энэрэн нигүүлсэх чанараа аврах ёстой – энэ бол хамгийн чухал. Бид эрхэм ариун чанараа аврах ёстой. Би үргэлж, ахин дахин давтан хэлдэг, бид энэ гараг дээрх зөвхөн физик оршнолыг авраад зогсохгүй, үр хүүхдүүдээ хамгаална, бид жинхэнэ мөн чанар, эрхэм ариун чанар, баатарлаг, нигүүлсэнгүй чанараа хамгаална. Тэднийгээ алдвал энэ дэлхийг алдсанаас дор юм болно. Бид зүрх сэтгэлийн энэрэн нигүүлсэн чанараа хадгалах ёстой.

Бид эрхэм ариун, үнэнч шударга байж, үр хүүхэд, өөрийгөө хамгаалах чадваргүй амьтад, сүл дорой, өрөвдөм бүхнийг хамгаалах ёстой. Бид эрхэм ариун Чанараа хамгаалах ёстой, бид амьсгалж, алхаж, амьд яваа Бурханы хүүхдүүд, Буддагийн шавь нар байх ёстой.⁷

Хайраас хайр л ундардаг

Хайрын ундарга байхын тулд бид хайрыг дадуулах ёстой. Эцэг Бурхан шигээ хайр энэрэлтэй, бүхнийг агуулсан байхын тулд бид бүх төрөлтнийг хайрлах ёстой. Ургамал (Веган) хүнсний цаана энэ бүх утга учир агуулагдаж байдаг. Үүнийг эрүүл мэндийнхээ төлөө, эсвэл Есүс тэгж хэлсэн, Будда хориглосон болохоор биш, бид зүгээр л хайрын төрөлтөн учраас хийх ёстой зүйл юм.

Бид энэ дэлхий дээр амьд Бурхан шиг байх ёстой. Бурханд ойр байхын тулд бид Бурхан шиг амьдрах ёстой. Бурхан биднийг шийтгэдэггүй, энэ нь яг л ижил нь ижилдээ татагддагтай адил. Хэрэв бид ямар нэг зүйлд ойр байхыг хүсвэл, тэнд очиж, тэр зүгт явах ёстой. Бурхан хамаг төрөлтнийг бүтээсэн, бас тэднийг байгалийн жамаар нь үхүүлдэг. Бид ч бас тэгэх учиртай. Бид бүтээж чадахгүй бол ядаж л устгах ёсгүй. Библид дурьдсан сахилд “Аллага үйлдэж болохгүй” гэсэн байдаг. “Зөвхөн хүний амь хороож болохгүй” гэж хэлээгүй, “Аллага үйлдэж болохгүй” гэж хэлсэн байдаг. “Амь хөнөөж үл болно.” Юуг ч алсан аллага болно.⁸

4 Хүн төрөлхтний бүхий л асуудлын шийдэл нь ХАЙР юм

Энэ материаллаг оршихуйд хамгийн эрхэм нандин зүйл нь хайр юм. Тиймээс бид хайрыг хамгаалах ёстой, хос хоёрын хайр байна уу, эцэг эх, үр хүүхэд, найз нөхдийн хайр байна уу хамаагүй. Хүмүүс хоорондын хайр, эсвэл амьтад хоорондын хайр, хүн амьтдын хоорондын хайр, эсхүл амьтад хүмүүсийн хоорондын хайр, үгүй бол бүр ургамал моддын хоорондын хайр байсан ч хамаагүй. Үнэндээ бол ургамал, модод хоорондоо харилцдаг. Тэд нэг нэгнээ хайрлан хамгаалдаг гэдгийг эрдэмтэд баталсан. Энэ тухай та нар уншиж мэдсэн байх. Эх дэлхийгээ хамгаалахын тулд ялангуяа энэ цаг үед бидэнд жинхэнэ хайр хэрэгтэй. Хайрласан бүхэн маань дэлгэрч дэвжинэ. Хайр биднийг аз жаргалтай болгодог. Гэхдээ хайр гэдэг жирийн нэг үг төдийхөн биш, хайр бол үйл хөдлөл бөгөөд үзэгдэх болон үл үзэгдэх хоёр хэлбэртэй байдаг.

Хайр дэлгэрч, бас устгагдах боломжтой хэдий ч хайрын мөн чанар хэзээ ч устаж алга болохгүй. Хайрыг тэтгэж тэлэх үйлс гэж байдаг, хагдруулан үхүүлэх үйлс ч бас бий.

Материаллаг хайрыг хэлж байгаа юм шүү. Энэ бол бидний оршихуйн хайр. Хайрыг тэлэх үйлс ч байдаг, хумьж багасгах үйлдэл ч байдаг. Хайрыг олбол түүнийг бид эрхэмлэн нандигнах ёстой. Дэмжих ёстой. Бид түүнийгээ бодол санаа, үг яриа, үйл хөдлөлөөрөө дэмжих ёстой.²

Бид хайрын үлгэр дуурайл байх боломжтой, тэгж ч чадна. Жишээлбэл, бусдад өгөх хайр, асран халамжлах хайр, эв эеийг бүтээх хайр, энэ бүхэн бусад хүмүүс биднийг санах, бодох, нэрийг маань санах бүртээ аз жаргал, хайр, ая тух, эрхэм ариуныг мэдрэхэд хүргэнэ. Тэр үедээ тэдний сайн чанар улам хөгжинө. Бид бусдын бодол, үйлдэл, ярианд дарамт шахалт, зовлон шаналал учруулах эх сурвалж болох учиргүй.

Бид бусдын хувьд урам зориг, эрхэм ариун чанар, хайрын эх ундарга байх ёстой, ялангуяа өөр хэн нэгнээс энэ үлгэр жишээг уламжлан авч суралцсан бол түүнийгээ түгээн дэлгэрүүлэх учиртай. Хайр байвал бүхий л сайн сайхан зүйлс бидэнд ирнэ. Бид одоо, өнөөдрөөс эхлэн хайрлаж, маргаашаас эхлэх ирээдүйд үргэлжлүүлэн хайрлах хэрэгтэй. ***Өөрийгөө хайрла, гэр бүлээ хайрла, хөршүүдээ хайрла, эргэн тойрныхоо бүгдийг хайрла.***

Зүрх сэтгэлд маань хайр үгүй бол бид хэн ч биш, өөрсдөдөө болон хайртай дотнын хүмүүстээ, нийгэмдээ

ачаа дарамт болно. Хайр гэдэг амнаас унах үг төдий биш, хайр бол бидний дотоод мэдрэмж, гаднаа илрэх үйлдэл байх ёстой.

Амьтдыг хайрладаг бол бид веган болно.

Дэлхийгээ хайрладаг бол ногоон амьдралын хэв маягаар амьдарна.

Дэлхийгээ хайрладаг бол гараг ертөнцөө аварна.²

Хэрвээ бид өөрсдийгөө дээд төрөлтөн гэж үздэг юм бол бид эрхэм ариуныг л үйлдэх ёстой – гэм зэмгүй, сул дорой нэгнийг хамгаалж, бидэнд ямар ч гэм хор учруулаагүй зүгээр л зэрэгцэн орших хувьтай анд нөхдөдөө хүч чадлаа үзүүлэн дарамтлан зовоох ёсгүй. Бид өнгөрсөн, одоо үеийн шашны ухаант мэргэн удирдагчдын хэлснийг санаж, амьтдыг Бурханы ариун нандин бүтээл гэдгийг мэдэж байх учиртай. Наад захын хүмүүжил, хүндлэл, энэрэн хайрлах ёс суртахуунаа бодвол бид ургамал хоолтон (веган) байх учиртай. Амьтан андуудаа хайрлаж, хүндэлбэл бид дотоодын мөн чанар, сүнслэг дэвшилд хүрнэ.

Энэ хайрыг бидэнтэй энэ дэлхий дээр зэрэгцэн оршдог амьтад хийгээд ертөнцийн бусад бүх төрөлтөнтэй

хуваалцах үедээ бид өөрснөө өргөжин тэлж, сүнсний хөгжлийн хувьд дэвшиж дээшилж байдаг. Аллага үйлдэлгүй, амьтдыг амар амгалан байлгавал бид Диваажингийн асар их адислалыг өөр дээрээ татна. Дэлхий нийтээрээ амьтдад нигүүлсэнгүй хандвал манай гараг дэлхийн уур амьсгал тогтворжиж, хайр энэрэл, амар амгалангийн Диваажин болж өөрчлөгдөнө.⁹

Хэрэв бид органик веган хандлагыг нэвтрүүлж, органик веган аж ахуй эрхэлж эхэлбэл, байгалийн хайрыг илүү мэдэрч, гараг дэлхийн хайр, моддын хайрыг, тэр бүү хэл өвсний ширхэг бүрээс ирэх хайр, цэцгийн хайрыг хүлээж авна. Амьсгалж буй агаараасаа хүртэл маш их хайрыг мэдрэх болно. Алхаж яваа газар дэлхийгээсээ маш их хайрыг мэдрэх болно. Үүнийг хүний хэлээр бүрэн тайлбарлах боломжгүй. Үүнийг зөвхөн мэдэрч л болно. Би энэ хайрыг үргэлж мэдэрдэг ч, энэ сүнслэг хэлийг бусад хүмүүст дамжуулж чадахгүй байна. Хүмүүс Диваажингаас заяасан веган хүнсний хэв маягийг амьдралдаа нэвтрүүлж чадсан тэр цагтаа энэ хайрыг илүү мэдэрч, цаг үргэлж холбогдсоор байх болно.¹⁰

Эхлээд веган болохыг зөвлөө. Органик жимс ногоо олдохгүй бол эхний ээлжид веган болоорой гэж хүсье. Учир нь энэ хайрын эерэг эрч хүч манай дэлхийг бүрхэж,

биднийг хамгаалагч бамбай болно. Өөр юу ч биш, аюул сүйрэл ойртсон энэ цаг үед өөр ямар ч хүч биднийг хамгаалж чадахгүй. Хичээнгүйлэн хүсэж байна, надад итгээрэй. Та бүхэнд ингэж хэлснээрээ надад хүртэх ашиг хонжоо гэж үгүй, би та нарын нэг учраас л ингэж хэлж байна, яагаад гэвэл миний хайр миний гэр бүл, надтай нутаг нэгтэй хүмүүс, эсвэл Солонгос хүмүүс юм уу, өөр улс үндэстний иргэн гэж хэн нэгнийг ялгаж заагладаггүй, би бүх хүнд хайртай. Энэ гараг дээр байгаа бүх төрөлтөнд би хайртай, би бүгдийг нь авармаар байна. Орон гэрээ шатахаас нь өмнө сэрээч гэж гуйя, бусдыгаа бас сэрэхэд нь туслаач гэж гуйя. Бид хамтдаа ялна, бид хамтдаа дэлхийгээ аварна. Энэ гарагийг аврах нь материаллаг зүйлсийн төлөө биш, өөрсдийгөө аврахын төлөө л юм.

Нигүүлсэнгүй, хайр энэрэлтэй, өршөөлтэй, Бурханлаг өөрийнхөө тэр мөн чанарыг бид аварна. Аливаа шашны сударт бид бол Будда, хүссэн үедээ бид Будда болж чадна, бид Бурханы хүүхдүүд гэж бичсэн байдаг. Тийм учраас бид ертөнцийн хамгийн аугаа төрөлтнүүд, Бурханы бүтээлийн титэм гэх өргөмжлөл хүндлэлээ хадгалах ёстой. Бид энэ хөлөг онгоцны ахмадууд. Бид энэ дэлхийг аюулгүй газар болгох үйл хэргийг манлайлан сүнсээ аварч, бидний дотор байгаа тэр сайн чанаруудаа

аврах ёстой.

Хамтдаа бид үзэсгэлэнт Жежү арал, Өмнөд Солонгос улсыг тэр чигээр нь гайхалтай диваажин хэвээр нь хадгалж чадахаас гадна дэлхийг бүхэлд нь аварна. Та нар бүгд баатар. Та нар цөм миний баатар. Веган байж, ногоон амьдралыг сонгон байгальдаа ээлтэй амьдраарай. Хайр дэлхийг өөрчилж чадна. Баярлалаа.¹⁰

Амьтдаас ирсэн захидал

Амьтад өөрсдийнх нь хардаг зүйлсийг хүмүүс хардаг ч болоосой, мэддэг зүйлсийг нь мэддэг ч болоосой гэж хүсдэг, тэгвэл энэ дэлхий дээр үдлэхийн төдий амьдралын төлөө энэ бүх галзуурлаа зогсоож, мөнхийн амьдралдаа илүү анхаарна гэж хүсдэг. Дэлхийг аврагдаасай гэж тэд хүсдэг. Дэлхийг аврахаас гадна, хүмүүс ёс зүйтэй амьдрал, энэрэл нигүүлсэлтэй зүрх сэтгэлээ эргээд олоосой гэж тэд хүсдэг юм. Тэд үүнийг мэддэг. Хүмүүс нигүүлсэнгүй бол, үүний дам нөлөөгөөр дэлхий аврагдана. Хэрэв бид хайрын хуулийн дагуу амьдарвал бүх зүйл зөв болно. Амьтад үүнийг мэддэг учраас хүмүүс энэ зарчмыг ойлгоосой гэж чин сэтгэлээсээ хүсдэг. Хайрын зарчим бол цорын ганц үндсэн зарчим.¹¹

Бид хэсэг хугацаанд бясалгаж дадуулсны дараа бүгдээрээ нэг гэдгээ, бүх зүйлтэй нэг гэдгээ, ертөнцийн хэдэн мянган зүйлтэй нэгдмэл гэдгээ, та болон би, таны “би” надтай нэг гэдгийг мэдрэх болно. Бид нэг эх үүсвэрээс гаралтай гэдгийг, билиг ухаан, хайр, нэгдлээс үүсэлтэй гэдгийг мэдэрнэ. Тийм учраас тэр нэг хүнийг юм уу, ертөнц дэх нэг төрөлтнийг сонгоод “Би тэр хүнд хайртай” гэх боломжгүй. Тийм биш үү!

Мэлмийгээс хөлийн ул хүртэл биеийнхээ нэг хэсгийг нь сонгож аваад тэр л хэсгийг харж хандаад байж болох уу? Энэ миний хамгийн хайртай эрхтэн гээд л, тэгж болох уу? Үгүй, үнэхээр утгагүй хэрэг. Магадгүй бид уруулаа их гоё гэж хэлж болох л доо. Миний үс сайхан гэж болно, эсвэл би хуруунууддаа дуртай гэж болох л юм. Гэхдээ бид биеийнхээ бүх эрхтэнд ялгаагүй хайртай. Яагаад гэвэл биеийн маань аль нэг эрхтэн байхгүй бол амьдрах боломжгүй. Биеийнхээ нэг хэсгийг огтлох юм уу, гэмтээчихвэл аз жаргалтай байж чадахгүй. Бие өвдөнө, үнэхээр их өвдөх болно, хэрвээ мэдэрч байгаа бол шүү дээ. Ямар ч мэдрэмжгүй болчихсон, эсвэл асуудалтай хүмүүс л галд хүрэх ч юм уу, биеийнхээ аль нэг хэсгийг гэмтээхдээ юу ч мэдэрдэггүй байх.

Хэвийн мэдрэмжтэй хүн биеийн аль нэг хэсэг нь өвдвөл шууд л мэдэрнэ. Тийм учраас л гэгээнтэн хүн машид энгийн нэгэн мөртөө бас жинхэнээсээ машид аугаа нэгэн байдаг. Яагаад гэвэл тэр бүхнийг мэдэрдэг. Тийм учраас л бид бусад төрөлтийг гэмтээдэггүй. Тийм учраас л бид веган болж өөрсдийгөө хамгаалж, бусдыг гэх хайраа хөгжүүлдэг. Яагаад гэвэл тэд бүгд бидэнтэй нэгдмэл нэг. Бид өөрийн жинхэнэ мөн чанараа хэзээ нэгэн цагт бүрэн олж авахыг хүсэж байвал, бүх төрөлтийг асарч хамгаалах учиртай, учир нь тэд бүгд бидний нэг хэсэг юм. Тийм л учиртай. Энэ бол сахил биш, бид энэ бүхнийг мэдэрдэг учраас л тийм байгаа хэрэг.

Диваажин хийгээд дэлхийтэй нэгдмэл гэдгээ дадуулах тусмаа энэ ертөнцийн амьд төрөлтөн нэг бүрийн мэдрэхүйд илүү мэдрэмжтэй болдог. Бид шууд л хар аяндаа л тэднийг хамгаалахыг хичээдэг болно. Мэдээжээр, зарим тохиолдолд үнэхээр зайлсхийх аргагүй үе гарна. Тэр үед бид хамгийн бага асуудалтай, байж болох хамгийн бага хохиролтойг нь жишээлбэл веган хүнс иддэг. Идэхгүй байхыг илүүд үздэг ч идэхээс өөр арга байхгүй билээ.¹²

Веган хүнс хамгийн харгислалгүй нь, веган хүнсийг сонгох нь хайраа үйлдэл болгохын жишээ юм. Тэгж бодохгүй байна уу? Тийм шүү, хэрвээ та амьтанд хайртай юм бол яагаад тэднийг иддэг юм бэ? Тийм ээ, хүн бүр л амьтдад хайртай гэдэг ч яагаад тэднийг иддэг юм бэ? Веган хоолны дэглэм дэлхийн дулаарлыг 80 хувиар бууруулж, аливаа харгислалыг үгүй хийнэ, бидний тавагнаас эхлэн дэлхий даяар хайр, энэрэнгүй эрч хүч өргөжин тэлж, усны хомсдол, усны бохирдол, хүнсний хомсдол, дэлхийн өлсгөлөн, дайн дажин зогсож, аюулт өвчнөөс сэргийлж, асар их хэмжээний татварын мөнгө, эмнэлгийн зардлыг хэмнэж, түүгээрээ улам сайхан дэлхийг бүтээн байгуулж, өөрсдөдөө хэрэгтэй шинэ зүйлсийг бүтээж, сайн үйлст хүмүүсийн байгууллагуудыг дэмжинэ гэх мэтээр сайн сайхан зүйлийн жагсаалт үргэлжилнэ.

Бид бүгдээрээ л энх амгалан дэлхийг хүсэж, энх тайван, хайрыг ямар их хүсэж байгаагаа ярьдаг. Тийм л юм бол бид яг энэ мөчөөс ажил хэрэг болгон энх тайвныг хоолныхоо тавган дээрээс эхлүүлье. Хайрын сонголтыг хийцгээе. Веган хоолны дэглэмийн бүх ач тусыг тоочоод баршгүй. Түүнд бас сүнслэг ач түс бий. Аливаа нэгэн төрөлтөн хүн болон амьтан ялгаагүй, шүүд болон шүүд

бусаар амь хөнөөхөд оролцсон хэн ч бай, өшөө авалт, харгислалын тойрогт ордог. Тэр үйлээ зогсоосон цагт л энэ бүхэн төгсгөл болно.

Тийм учраас бид дайснаа ч хайрлах ёстой. Учир нь зөвхөн хайр, уучлал л үзэн ядалт, өшөө хорслын сөрөг үр нөлөөг тасалдаг хүчтэй. Энэ тухай өнгөрсөн үеийн бүх Их Багш, Гэгээнтнүүд аль хэдийнээ ярьчихсан билээ.¹³

Дэлхийг веган болоосой, энх амгалан болоосой гэж би хүсдэг. Би үүнийг л хүсэж байна. Би өдөр бүр энэ үгийг Диваажинд давтан хэлж, Тэд намайг сонсож буй эсэхийг бататгаж байдаг. Бидэнд туслаарай гэж. Учир нь Дэлхий веган болохгүйгээр энх амгалан яагаад ч тогтохгүй. Тийм учраас би хүмүүст зөвхөн Веган Дэлхийн төлөө залбирч бясалгаарай гэж захидаг юм. Тэгвэл Дэлхийд аяндаа энх тайван тогтоно. Дэлхий улам л веган болох тусам, энх тайван илүү батажна. Гэхдээ энх тайван үргэлжийн мөнхөд байх учиртай. Өмнөхөөсөө хавьгүй сайжирсан хэдий ч миний хүссэн хэмжээнд хүрээгүй л байна. Олон хүн веган болсон. КОВИД-19-ийн хөл хорионы үеэр хүмүүст цаг зав гарч байна. Тэдэнд хамтдаа, эсвэл ганцаараа, гэр бүлтэйгээ, ойр дотнынхонтойгоо, эсвэл нэг хоёр хүнтэй хамт суугаад ахиухан тунгаан бодох цаг хугацаа олдож байна. Өнөө үед веган чиг хандлага улам

нэмэгдэж байна. Энэ хандлага дэлхий дахинд тархвал манай гараг дээр амьтдын зовлон үгүй болж, хүмүүс дайн дажин, өлсгөлөнгөөс болж дахин зовохгүй.

Би дэлхийн бүх удирдагчдад хандан дайн дажин гэх мэтийн огт хэрэггүй зүйлд мөнгө үрэхгүй байхыг, ахиухан хэмнэлттэй байхыг зөвлөж байна. Мөнгөө хадгалж, ядууст зориулаарай. Тэдэнд амьдралаа шинээр эхлэхэд нь тусалж, бизнес эрхлэх, боловсрол эзэмших, эсвэл махны бизнесээс органик веган бизнес руу шилжихэд нь зориулж туслаарай гэж захимаар байна. Энэ маш амархан. Тэд өөрсдийгөө болгоод л явна. Олон хүн веган болох тусам Засгийн газрын удирдагчдад санаа зовох зүйл бага гарна. Учир нь тэд хийх ажилтай, мөнгө олж өөрсдийгөө тэтгэж чаддаг бол засгийн газарт төвөг удахгүй. Дэлхий дээр өвчин зовлон буурч, гэмт хэрэгтнүүд цөөрнө. Тэгвэл бүгдэд нь сайн.

Би ийм л зүйлийг хүсдэг. Веган Дэлхий, Амгалан Дэлхийтэй болох сон гэж Бурханы нэрийн өмнөөс хүсэж байна. Бурханы өршөөл ивээлээр удахгүй биелэх болтугай. Амен.¹⁴

5 Дотоодын хийгээд Дэлхий дахины амар амгалангийн төлөөх бясалгал

Амар амгалан биднээс эхэлнэ, надаас, танаас эхэлнэ, дараа нь дэлхий дахин амар амгалан болно. Тийм учраас, хэрвээ бид бясалгал хийж, мах идэхээ зогсоовол бүхий л биеэрээ амар амгалан болох юм. Бид өөрсдөө илүү амар амгалан байх юм бол үл үзэгдэх тэр амгаланг орчин тойрондоо цацруулж, тэр нь хүн бүхэнд нөлөөлнө. Ингээд бид амар амгалангийн тухай ярих биш, өөрөө аяндаа биелчихнэ. Энх тайвныг сурталчлах ч шаардлагагүй, өөрөө хүрээд ирнэ.¹⁵

Бясалгал одоо их нэр хүндтэй болжээ. Хүмүүс “Бурханыг эрж олохын тулд бясалга” гэхийн оронд, харин “Амарч тайвшрахын тулд, эрүүл саруул болохын тулд, сэтгэл санаагаа тайвшруулахын тулд, урт наслахын тулд, амжилтын төлөө бясалга” гэдэг болж. Бүх талаараа амжилттай байхын тулд өдрийн нэг цаг амрах, гэхдээ унтах бус, харин бясалгах хэрэгтэй гэх юм. Үүнийг шинжлэх ухаан баталчихсан учраас хүн бүр мэддэг болжээ. Өдрийн тодорхой цагт амрах, эсвэл бясалгал хийвэл бидний бие махбод улам эрүүл болдог. Хамгийн

шилдэг аргын нэг бол бясалгал, тийм учраас өдөр бүрийн аль нэг цагтаа бясалгал хийгээрэй.

Энэ цаг бол таны хувьд нэн эрхэм. Бид өдөржин ажиллаж, дэлхийн хэрэг, бусдын хэргийг харж хандаад завгүй байдаг. Тийм учраас бясалгах цаг хугацаа бол бидний өөртөө зарцуулах цаг юм. Эхлээд өөрийгөө хайрла, бусдыг ч бас хайрла, тэгэхийн хамт өөрсдийгөө ч бас хайрлаарай.

Бясалгах нь танд их сайн нөлөөтэй. Төрөхөөс үхэх хүртэлх амьдралын тань хамгийн үнэтэй цаг бол бясалгалд зориулсан цаг. Энэ бол таны өөрийнхөө төлөө хийж чадах хамгийн сайн зүйл. Үүнийг хэн ч танд өгч чадахгүй; зөвхөн та л өөртөө өгч чадна. Та өөрийнхөө төлөө бясалгаж байхдаа бусдад ач тус хүргэдэг. Гэр бүл, хамаатан садан, муур, нохой тань хүртэл ач тусыг нь хүртэнэ. Мод, цэцэг хүртэл ач тус хүртдэг.¹⁶

Яагаад гэвэл бясалгал бол таны жинхэнэ хамгаалалт юм. Энэ үед та өөрийнхөө тэр нэг аугаа хүчтэй бүр ихээр холбогддог, таныг тэтгэж, хамгаалж, хайрлаж, таныг бүхий л хайр, адислал, хамгааллаар тэвэрч байдаг ертөнцийн тэр хүчтэй холбогддог. Үнэхээр тийм. Энэ дэлхийд та нарыг хамгаалах өөр тийм хүч байхгүй. Энэ л

нууц нь юм. Энэ бол хүмүүсийн ойлгодоггүй, эсвэл мэдэх аз завшаан тохиогоогүй тэр нууц юм, гэхдээ заримдаа хүмүүс түүнийг байдаг л нэг зүйл мэт бодоод бэрхшээл зовлон тохиох, өвчин тусах үедээ гарч эм уугаад эмчид талархах жишээтэй байдаг. Сүнслэг хөгжил тань хангалттай хүчтэй биш, үйлийн үрдээ гүйцэгдэх үе гарвал та эмчид очих хэрэгтэй. Гэвч бидний дотоодод анагаах хүч бий. Бид үргэлж эрүүл энх байж, өөрсдийгөө харж хандан хүмүүс олноороо сэрж мэдрээд хувь нэмрээ оруулах хүртэл дэлхийг үүрэлцэх хүч чадалтай байж чадна.¹⁷

Дэлхий дээрх бидний зорилго

“Хүн болж төрсний цорын ганц зорилго бол Бурханыг таних явдал юм. Хэрэв бид энэ үүргээ огоорвол энэ төрөлдөө ч, дараагийн бүх төрөлдөө ч хэзээ ч аз жаргалтай байж чадахгүй. Үнэнийг хэлэхэд хүний зовлонгийн цорын ганц шалтгаан нь өөр юу ч биш. Эхийнхээ хэвлийд бид хэрхэн зовж тэмцэж, өнгөрсөн төрлүүддээ хийсэн алдаа дутагдалдаа хэрхэн харамсаж, төрөхөөсөө өмнө энэ олдсон төрлөө хамгийн утга учиртай өнгөрөөнө гэж Бурханд амлаж байснаа, түүнд үйлчлэхээ амлаж байснаа санавал бид өөр зүйлийн тухай бодоход нэг ч секундийг үрэхгүйгээр завтай бүх

цаг хугацаагаа Бурханыг таньж мэдэхийн төлөө зориулах болно!

Гэвч энэ дэлхийд төрмөгцөө бид бүхнийг мартчихдаг. Яагаад гэвэл материаллаг ертөнцийн хууль нь хүмүүсийг мартаход хүргэдэг юм. Тийм учраас Их Багш бууж ирэн эхийнхээ хэвлийд байхдаа Бурханд юу гэж амласнаа санах хүртэл маань бидэнд хэлж сануулсаар байдаг. Бид уураг тархи, оюун ухаанаараа санахгүй байж болох ч сүнс, билиг ухаан маань санаж байдаг юм.”¹⁸

Бясалгал: Жинхэнэ Мөн чанараа хэрхэн санах вэ?

“Нэгэн үзүүрт сэтгэлээр, чин сэтгэлээсээ нэг зүйлд анхаарлаа бүрэн хандуулах мөч бүр бясалгал юм. Одоо би зөвхөн дотоод Хүчинд, энэрэл нигүүлсэлд, хайранд, Бурханы өршөөлт чанарт анхаарлаа хандуулж байна, энэ бол бясалгал. Ингэхийн тулд бид чимээгүй буланд ганцаараа суух хэрэгтэй, энэ бол бясалгалын үйл явц. Гэвч хүн аль нэг буланд чимээгүй сууснаараа юм олоод хүртчихдэг юм биш. Эхлээд дотоод хүчтэйгээ холбогдсон байх ёстой бөгөөд тэр дотоод Хүчээ ашиглан бясалгадаг юм. Үүнийг Өөрөө сэхээрч ухаарахуй гэдэг.

Бид дотоодын тэр Мөн чанараа сэрээчихвэл тэр маань бясалгадаг, бидний тархи, бидний ёс суртахууны ойлголт бясалгадаг юм биш. Үгүй бол суугаад л байгаа боловч мянга мянган зүйл бодсоор, элдэв хүслээ дарж чаддаггүй. Гэвч таны тэр Мөн чанар, дотоодын жинхэнэ Би сэрчихсэн үед бол харин таны дотоодын Бурханы хүч бүхнийг удирдана. Жинхэнэ Их Багшаас авшиг хүртэж сэрснийхээ дараа та жинхэнэ бясалгалыг мэддэг. Тийм биш бол, бие сэтгэлтэйгээ тэмцэлдэн суух нь дэмий цагийн гарз л болно.”

Их Багш гэж хэн бэ, бидэнд яагаад хэрэгтэй вэ?

“Их Багш гэдэг бол та нарыг Их Багш болгох түлхүүртэй Нэгэнийг хэлдэг... та нар ч бас Их Багш гэдгийг, Бурхан та хоёр Нэг гэдгийг ухаарахад тань тусалдаг Нэгэн юм. Ердөө л энэ... Их Багшийн цорын ганц үүрэг нь энэ.”

“Их Багш нар гэж анхдагч Эх сурвалжаа санадаг тийм Хүмүүсийг хэлдэг, тэдний хайр тэр мэдлэгийг эрж хайж яваа бүгдтэй хуваалцахыг хүсдэг, хариуд нь ямар ч төлбөр, ач тус нэхдэггүй тийм л хайр. Бид хамаг л цаг хугацаа, хөрөнгө мөнгө, эрч хүчээ дэлхийд зориулдаг. Бид тэдний төвшинд хүрснийхээ дараа Анхдагч Эх

сурвалжаа мэдээд зогсохгүй, бусдад жинхэнэ үнэнийг мэдэхэд туслах боломжтой. Их Багшийн зааварчилгааг дагадаг хэн бүхэн, тэр даруй жинхэнэ мэдлэгээр дүүрэн, жинхэнэ гоо үзэсгэлэн, жинхэнэ ариун журамтай шинэ ертөнцийг мэдчихдэг юм.”

Авшиг

“Авшиг бол шинэ төлөв байдал, шинэ амьдралын эхлэл. Энэ нь Их Багш таныг Гэгээнтнүүдийн орчлын нэгэн төрөлтөн болсныг зөвшөөрөн хүлээж авсан гэсэн үг. Та энгийн төрөлтөн байхаа больж, дэвшжээ, яг л та ахлах сургуулийн сурагч байхаа больж, их сургуульд элссэнтэй нэгэн адил. Эрт дээр үед тэд үүнийг усан баталгаа, эсвэл Их Багшид аврал одуулах хэмээн нэрлэдэг байв.

Авшиг гэдэг нь үнэндээ сүнсийг нээх гэсэн утгатай үг юм. Бид үл үзэгдэх болон үзэгдэх янз бүрийн олон саад бэрхшээлийн дунд байдаг учраас авшиг гэх зүйл нь билиг ухааны хаалгыг нээх үйл явц бөгөөд түүнийг энэ дэлхий руу урсгаж, дэлхийг болон бас таны Мөн чанар гэдэг тэр зүйлийг адисалдаг. Гэвч жинхэнэ Мөн чанар үргэлжийн сүр жавхлантай, билиг ухаантай байдаг учраас түүнийг адислах шаардлага байхгүй.

Арьяабалын Арга – дотоодын Гэрэл, Аялгууны бясалгал

Дотоодын Гэрэл, Бурханы Гэрэл нь “Гэгээрэл” хэмээх үгэнд орсон Гэрлийг хэлж зааж байгаа юм. Дотоодын Аялгуу гэдэг нь Библид дурдсан тэр Үг юм: “Эхэндээ Үг байсан, Үг Бурхан байсан” гэдгийн Үг юм. Дотоодын Гэрэл, Аялгуугаар дамжуулан бид Бурханыг мэддэг.

“Тэгэхлээр бид тэр Үг, эсвэл Аялгууны Урсгалтай холбогдож чадвал, Бурхан хаана байгааг мэднэ, Бурхантай холбогдох боломжтой. Харин энэ Үгтэй холбогдсоны баталгаа нь юу вэ? Энэ дотоод Хэлбэлзэлтэйгээ холбогдсоны дараа бидний амьдрал сайн тийшээ өөрчлөгддөг. Урьд өмнө мэдэж байгаагүй олон зүйлийг мэддэг болдог. Урьд өмнө хэзээ ч бодож байгаагүй олон зүйлийг ойлгоно. Өмнө нь зүүдэлж ч байгаагүй олон зүйлийг хийж, бүтээж чадна. Бид улам бүр аугаа болсоор байх болно. Бид илүү чадварлаг болж, тэлж томорсоор хаа сайгүй оршигч болж, энэ үедээ Бурхантай нэг болсноо мэдэх болно.”

Таван Сахил

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай шашин шүтлэг, үндэс угсааг үл харгалзан бүх хүнд авшиг хүртээдэг. Та өөрийн шашин шүтлэг, сүсэг бишрэлээ өөрчлөх шаардлагагүй. Таны өнөөгийн амьдралын хэв маягт таарч тохирохгүй ямар нэгэн байгууллагад элсэх, үйл ажиллагаанд нь оролцохыг шаардахгүй. Гэхдээ таныг веган болохыг л хүснэ. Авшиг хүртэхийн тулд тавигддаг нэг болзол нөхцөл бол насан туршдаа веган хоолтон байх явдал юм.

Авшигийг үнэ төлбөргүй уламжилдаг. Авшиг хүртсэний дараа танаас зөвхөн Арьяабалын Аргаар өдөр бүр бясалгаж, Таван Сахилыг сахихыг л шаардана. Эдгээр сахил нь таныг өөртөө болон өрөөл бусад амьд төрөлтөнд ямар нэгэн хор хөнөөл учруулахаас сэргийлнэ.

- Аливаа төрөлтний амь таслахыг цээрлэ. Энэ сахил нь веган хоолтон байхыг хатуу шаарддаг. Ямар ч мах, загас, шувуу, өндөг, сүүн бүтээгдэхүүн хэрэглэж болохгүй.

- Үнэн бус зүйл ярихыг цээрлэ.

- Өөрийн бус зүйл авахыг цээрлэ.

- Зүй бус бэлгийн харилцаанд орохыг цээрлэ.

- Мансууруулах бодис хэрэглэхийг цээрлэ. Үүнд архи, тамхи, хар тамхи, мөрийтэй тоглоом, садар самуун бичлэг болон хэт харгис кино, уран зохиол зэргээс зайлсхийх багтана.

* Мөн өдөр бүр 2 цаг 30 минут Гэрэл, Аялгууны бясалгал хийнэ.

Эдгээр дадал нь гэгээрлийн анхны ахуй ойлголтыг тань төлөвшүүлж, улам гүнзгийрүүлэн эцэстээ хамгийн дээд төвшний Сэхээрэхүйг олж, Буддагийн хутагт хүрэх боломж өгнө. Өдөр тутмын бясалгалаа хийхгүй бол гэгээрлээ магад мартахад хүрч, ухамсрын доод төвшинд унана.¹⁸

Энэ бүх бурхан чанарыг бид хэзээ ч гэсэн эргүүлэн олж авах боломжтой. Бид үүнийг үнэхээр хүртэх боломжтой гэдгийг би чин шударгаар, нэр төртэйгөөр амлаж байна. Хаа нэгтээ сууж байгаа та хэдэн настай байсан ч хамаагүй, Диваажингийн тухай ямар ч ойлголтгүй байсан ч, урьд нь ямар нэгэн авьяасгүй ч байсан хамаагүй, яаж бясалгахаа мэддэггүй байсан ч хамаагүй, хэнбугай ч энэ бурхан чанарыг олж чадна, бас дахин олж авч чадна, зөвийг үйлдэж байвал бид эргүүлэн авч чадна.

Тэгэхлээр анхны алхам бол илүү нигүүлсэнгүй

амьдралын хэв маягт шилжих явдал, учир нь бид бол энэрэл нигүүлсэлтэй нэгэн билээ. Энэрэнгүй веган хоолны дэглэм нь дээд төрөлтний зам мөр, жинхэнэ хүмүүний шинж тэмдэг юм. Жинхэнэ хүмүүн хэзээ ч аллага үйлдэхгүй. Жинхэнэ төрөлтөн хэзээ ч өөр нэгнийг гэмтээхгүй, өөрийнх нь амь насанд аюул тулгарсан байлаа ч тэгэхгүй. Жинхэнэ соёлт хүмүүн бүх төрөлтнүүд хоорондоо холбоотой гэдгийг ухаарсан, аллага үйлдэн амь хороовол өөрийн сүнсийг эрсдэлд оруулж, аллагын муу үр дагаврыг өөртөө авна гэдгийг мэдчихсэн учраас үүнээс зайлсхийнэ.

Тэгэхлээр, дэлхийн ухамсрын төвшнийг дээшлүүлэх нь зөвхөн энэ хүүхдүүдийн үүрэг биш - Диваажинг дэлхийд ойртуулахын тулд бид бүгдээрээ хамтдаа хичээн ажиллах ёстой. Бид үүнийг хийж чадна, үнэхээр амархан. Манай бүлэгт 5-6 настай хүүхдүүд хүртэл бясалган дотоодын аялгуугаа сонсож, Бурхантай ярьж чаддаг. Хэрвээ бид дэлхий дээр Диваажинг цогцлоохыг хүсэж байгаа бол, хэрвээ энэ нь бидний хүсэл мөн л юм бол, үүнийгээ биелүүлье.¹⁹



Бидэнтэй хэрхэн холбогдох тухай

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай Багаас Арьяабалын
бясалгалын авшиг хүртэх тухай дэлгэрэнгүй мэдээлэл
авахыг хүсвэл дараах интернэт хаягаар ороод манай
бясалгалын төвүүдийн жагсаалтаас өөртөө аль ойрхон
төвтэй холбогдоорой.

www.GodsDirectContact.org.tw/eng/cp/index.htm



Төгс Гэгээрсэн Их Багш

6 Чин Хайн бүх Шашны болон Оюун санааны удирдагчдад илгээсэн захидал



Эрхэм Хүндэт Тэгээнтнүүд, Олын Хүндлэлийг хүлээсэн бүхий л шашны Лам, Хувраг, Жомлогч, Тэлэн, Тэлэнгана та бүхэндээ хамгийн сайн сайхныг хүсэн өрсөж, эрүүл энх байхыг Бурханы өршөөлд даатган залбирлаа өргөж байна. Веган Дэлхий, Энх тайван Дэлхийн төлөө гүн даван басалгал хийж байгаа надад олдох цаг хугацаа хязгаартай, асар үнэ цэнтэй хэдий л манай гараг дэлхийд үүсээд байгаа нөхцөл байдлын улмаас ийнхүү яаран та бүхэнд хандаж байна. Эрхэм Хүндэт Тэгээнтнүүд, Ариун санваартнууд та бүхэндээ энэ яаралтай илгээлтийг заавал дүүргэх ёстой гэж би мэдэрсэн. Сүнсэлэ хөгжлийн аугаа удирдагчид та бүхэн гараг дэлхийд маань үүрчлээд буй энэ их гай гатшиг нь хүмүүсийн хэрцүү авир, харгислагыг дагалдсан гадал зуршлаас үүдэлтэй цур амьсгалын өөрчлөлттэй шүүд холбоотойг мэдэх буй за. Хайрын зарчмыг хэрэгжүүлбэл энэ



харгис дадлыг өөрлөх тийм ч хэцүү биш. Энэ үзнийг
сүсэгтэн олондоо дамжүүлна уу. Бид өөрлөгдөх ёстой
гэдгийг тэдгэнд хэлээрэй. Учир нь БИД БҮРХААНИ
ХҮҮХДҮҮДИЙН АЖИЙТ ХӨНӨӨЖ БАЙТАА
ЦАТГ ӨӨРСДИЙТӨӨ БҮРХААНИ ХҮҮХДҮҮД
ТЭЖ ҮЗЭХ БОЛОМЖТҮЙ. Энэ удаад хүтүүний,
эсвэл амьтны төрлийг авсан ИРЭЭДҮЙН БҮДДА
НАРБИТ ҮЙ ОЛНООР НБ ХӨНӨӨЖ БАЙТАА
ЦАТГ ӨӨРСДИЙТӨӨ ИРЭЭДҮЙН БҮДДА ТЭЖ
ҮЗЭХ БОЛОМЖТҮЙ. БҮРХААНД ХАЙРГАЙ
ТЭСЭН МӨРГЛӨӨ ГҮҮЖИЙ БҮГЭЭЛИЙТ ХАЙР
НАЙРТҮЙ ХӨНӨӨЖ ЦЕГТАЖ БОЛОХТҮЙ.
ОДОО БИД ГҮҮЖИЙ БҮГЭЭСЭН ТАРАТ
ДЭЛХИЙТ СӨНӨӨЖ БАЙНА. Та бүхнээс үлгэр
дүүрайл авдаг. Ариун гэгээнтэн, Хүндэт таныг энэрэл
нигүүлсэл, хайрын бэлгэдэл хэмээн дээдэлдэг итгэл,
дагалдаг нартаа үүнийг ахин дахин зааж сургаарай.
Бурханы Хайрын хатт, баярлалаа.

Эрхэм Хүндэт Гэгээнтнүүд, Олны Хүндлэлийг хүлээсэн бүхий л шашны Лам, Хувраг, Номлогч, Гэлэн, Гэлэнмаа та бүхэндээ хамгийн сайн сайхныг хүсэн ерөөж, эрүүл энх байхыг Бурханы өршөөлд даатган залбирлаа өргөж байна. Веган Дэлхий, Энх тайван Дэлхийн төлөө гүн даяан бясалгал хийж буй надад олдох цаг хугацаа хязгаартай, машид үнэ цэнтэй хэдий ч бидний гараг дэлхийд үүсээд байгаа нөхцөл байдлын улмаас ийнхүү яаран та бүхэнд хандаж байна. Эрхэм Хүндэт Гэгээнтнүүд, Ариун санваартнууд та бүхэндээ энэ яаралтай илгээлтийг заавал дуулгах ёстойгоо би мэдэрсэн юм. Бидний гэр галд шатаж байвал, “Үүнийг зохицуулах цаг надад алга” гэж хэлж болохгүй шүү дээ. Дэлхий гэр маань шатаж байна!!! Тийм учраас энэ захидлыг илгээх нь бидний нэгдмэл зорилгын төлөө юм. Үүнийг шуудангаар илгээх ёстой ч би шууд уншаад өгье. Илүү хурдан. Цаг хугацаа давчуу байгаа үед дэндүү их хүнд суртал гаргах хэрэггүй.

Хүндэт Гэгээнтнүүдээ... Хэдийгээр өөр өөр шашин шүтлэгтэй ч бид нэг Бурханд үйлчилдэг гэдэгт би итгэдэг. Хүндэт Гэгээнтнүүд та бүхний энэ олон он жилийн түршид Оройн Дээд Бурханы хайр нигүүлслэлийн илгээлтийг хүн төрөлтөн хийгээд бусад бүтээлд түгээж, хүмүүсийг нэгтгэхийн төлөөх эрхэм нандин бүхнээ

зориулсан үйлсэд тань бид гүнээ талархаж байна, би талархаж байна. Танд баярлалаа. Бурхан үргэлж Таны талд байх болтугай.

Оюун санааны удирдагч болохын хувьдаа та бүхэн гараг дэлхийд маань нүүрлээд байгаа гай гамшиг нь хүний хэрцгий авир болоод харгис дадлаас үүдэлтэй уур амьсгалын өөрчлөлттэй шууд холбоотой болохыг мэдэх буй заа. Хайрын зарчмыг баримталбал энэ харгис дадлыг өөрчлөх тийм ч хэцүү биш. Энэ үнэнийг сүсэгтэн олондоо дамжуулаарай. Бид өөрчлөгдөх ёстой гэдгийг тэдэнд хэлээрэй. Өөрсдийгөө хүн гэж хэлэхийг хүсвэл, ирээдүйн Будда, Бурханы хүүхдүүд гэж хэлэхийг хүсэж байгаа бол бид өөрчлөгдөх ёстой. Учир нь БИД БУРХАНЫ ХҮҮХДҮҮДИЙН АМИЙГ ХӨНӨӨЖ БАЙГАА ЦАГТ ӨӨРСДИЙГӨӨ БУРХАНЫ ХҮҮХДҮҮД ГЭЖ ХЭЛЭХ БОЛОМЖГҮЙ ЮМ.

Хүний ч байна уу, амьтны ч байна уу хэлбэр дүрстэй ИРЭЭДҮЙН БУДДА НАРЫН АМИЙГ ҮЙ ОЛНООР НЬ ХӨНӨӨЖ БАЙГАА ЦАГТ ӨӨРСДИЙГӨӨ ИРЭЭДҮЙН БУДДА ГЭЖ ХЭЛЭХ БОЛОМЖГҮЙ. Буддын шашны судруудыг судалбал Шагжамуни Будда хүртэл тоолшгүй олон удаа амьтны төрөл авч байсныг бид мэднэ. Мөн Библид, Бурхан олон төрлийн ургамал ногоог амьтад хоолондоо

хэрэглэг хэмээн бүтээжээ, бас бидэнд зориулж олон зүйлийг бүтээсэн гэж гардаг. Хэрэв амьтад Бурханы хувьд юу ч биш байсан бол Бурхан тэдэнд зориулж идэх зүйлс бэлдэхгүй байхсан. Энэ нь Бурхан биднийг хайрлаж, бидэнд идэх зүйл бүтээсэнтэй яг адил юм. Бурхан газарт ургах жимс ногоог бүтээсэн бөгөөд тэр нь бидний хоол юм гэж Библид бичсэн байдаг. (Ариун Библи, Женесис 1:29)

БУРХАНД ХАЙРТАЙ ГЭСЭН МӨРТЛӨӨ БИД ТҮҮНИЙ БҮТЭЭЛҮҮДИЙГ ХАЙР НАЙРГҮЙ ХӨНӨӨЖ УСТГАЖ БОЛОХГҮЙ. ОДОО БИД ТҮҮНИЙ БҮТЭЭСЭН ГАРАГ ДЭЛХИЙГ СӨНӨӨЖ БАЙНА.

Хүн төрөлтөн жил бүр хүнсний хэрэгцээндээ зориулан 74 тэрбум амьтныг харгис хэрцгийгээр хөнөөж, мал аж ахуйн салбар болон түүний дам бүтээгдэхүүнүүдийн үйлдвэрлэл нь хүнээс үүдэлтэй хүлэмжийн хийн 87 хувийг ялгаруулж байна. Идэж буй хүнсээрээ дамжуулан бид гараг дэлхийгээ сүйтгээд зогсохгүй, ямар ч буруу зүйл хийгээгүй гэм зэмгүй амьтдад үгээр илэрхийлэхийн аргагүй өвчин шаналлыг үүрүүлж байна. Гэтэл Бурхан амьтдыг бидний найз, туслагч байхаар бүтээсэн болохоос хэрцгийлэн хороож, идэг гэж бүтээгээгүй. Бурхан минь, бид 21-р зуунд амьдарч байна шүү дээ.

Ариун Библи, Жоб 12:7-8-д: “Гэхдээ амьтдаас асуу, тэд заагаад өгнө, тэнгэр дэх шувуудаас асуу, тэд хэлээд өгнө. Газар шороотой ярь, танд заагаад өгнө, далай тэнгис дэх загас танд мэдээлэл өгнө” гэж бичсэн байдаг. Тэгэхлээр Бурханы бүтээсэн амьтад хийгээд газар дэлхий бол ухамсартай, хүндтэй төрөлтнүүд бөгөөд тэдний оршин буй нь хүн төрөлхтөнд өгсөн аугаа их адислал аж.

Диваажинд байгаа Эцгийнхээ бүтээлүүдэд бид ямар уучилшгүй зан авир гаргаж Бурханы хуулийг зөрчинө вэ? Далай тэнгисээс өгсүүлээд газар шороон дээрх Бурханы бүтээлүүдийг бид сүйтгэж байна! Лабораторийн туршилт, мал аж ахуй, загас агнуур, өндөгний үйлдвэрлэл, сүү, үслэг эдлэл, гоо сайхны үйлдвэрлэлд Бурханы хүүхдүүд болох гэм зэмгүй үй олон төрөлтөн, бүтээлд маш харгис хэрцгий хандаж байна. Энэ бүх аж үйлдвэр гэгч нь ямар их аймшигтай, хүнлэг бус гэдгийг хэн ч үгүйсгэж чадахгүй. Бидэнтэй зэрэгцэн орших гэм зэмгүй, өөрийгөө хамгаалах чадваргүй, эелдэг зөөлөн Бурханы хүүхдүүд болох амьтан андуудаа хашиж хорьж, янз бүрээр тамлан хүчирхийлж, өөрсдийгөө хамгаалан тусламж гуйж нэг үг хэлэх ч сөхөө өгөхгүй зовоож байна! Тусламж гуйж дуугарлаа ч, үр төлийг нь авч яваад зодож өшиглөн алж байхад эх үнээ, эх гахай үйлж байхад хэн ч тоодоггүй.

Таван настай хүүхэд ч тэдний сэтгэлийг ойлгоно. Энэ бол олон тамын шаналлаас долоон доор! Тэд бидний үр хүүхэд, хамаатан садан, найз нөхөд байсан бол гээд төсөөлөөд үз дээ, эсвэл бид өөрсдөө тэдний оронд байсан бол гэж төсөөлөөд үз дээ! Тэд бол сэтгэл хөдлөл, бодол санаа, сэрэл мэдрэмжтэй амьд төрөлтнүүд. Гэрийн тэжээвэр амьтантай хамт цаг хугацаа өнгөрүүлсэн хүн нэг бүр тэднийг өөрсдийн гэсэн зан авиртай, хайр, халамж, өвдөлт зовуурь, үй гашуу, аз жаргал, сэтгэл догдлол зэргийг мэдэрдэг гэдгийг нь сайн мэднэ. Тэд үнэнч, туйлын үнэнч. Мал аж ахуйн үйлдвэр, фермийн уйтан хашаанд нэг насаараа үй олноороо чихцэлдэн бохир заваан орчинд нар борооноос халхлах зүйлгүй, цаг агаарын янз бүрийн нөхцөл байдал, төсөөлөхийн аргагүй элдэв харгислал зовлон эдлэн тэсчхээд эцэст нь нядалгааны газар харгисаар амиа егүүтгүүлдэг амьтад болон гэрийн тэжээвэр амьтны хооронд ямар ч ялгаа байхгүй. Тэднийг хүний хүнсний хэрэглээнд зориулж л ингэж тамладаг. Өөрсдийгөө бид хүн гэж бодсоор байвал шүү дээ.

Илүү дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл, “Кауспираси”, “Дэлхийнхэн” “Доминион” зэрэг шагналт кино, “Эрүүл мэнд гэж юу вэ” зэрэг шагналд нэр дэвшсэн баримтат

киног үзэхийг санал болгож байна. Мөн Crisis2Peace.org веб хуудаснаас “Хямралаас энх тайванд” номыг үнэ төлбөргүй татан авч уншиж үзээрэй.

Бүхий л томоохон шашны сударт үүнтэй адил төстэй зүйлийг сургаж номлосон байдаг, жишээ нь “Бусдыг өөртөө яаж хандуулахыг хүснэ, яг түүн шигээ бусдад ханд”, мөн “Аллага бүү үйлд.” “Ахимса” буюу харгислалыг үл үйлдэх гэх мэт нийтлэг зарчмыг дурдсан байдаг. Мэдээж, итгэл сүсэг бишрэлийн бүх системд, ариун сударт ямарваа нэгэн мэдрэхүйт төрөлтнийг идэхийг хатуу чангаар хорьдог. Гэтэл Бурханы их олон хүүхэд, шашинд сүсэлж бишрэн итгэгч энэ үндсэн сургаалыг дагаж мөрддөггүй. Яагаад гэвэл амьтны мах, загас, өндөг, сүү хэрэглэвэл эрүүл мэндэд тустай гэсэн буруу ойлголт, үзлээр тэднийг төөрөлдүүлжээ. Харин ч эсрэгээрээ идэхгүй байх нь тустай – шинжлэх ухааны, анагаах ухааны салбарын олон шинжилгээ судалгаанд амьтдыг идэх нь хүмүүс олон төрлийн өвчин үүсгэж байна, тухайлбал төрөл бүрийн хорт хавдар, зүрх судасны өвчний шалтгааныг үүдэж, эрт үхэхэд хүргэж байгааг, мөн нас эцэслэхийн өмнө тасралтгүй зовж шаналдаг болохыг тогтоожээ. Зөвхөн өвчтөнүүдэд төдийгүй хамаатан садан, найз нөхөд, гэр бүлийнхэн, хайртай

хүмүүстээ маш их сэтгэлийн шаналал зовуурь үлдээдэг аж.

Одоо цаг нь иржээ, эдгээр бие махбод болон сүнслэгийн хувьд гажиг, эрүүл бус, хор хөнөөлтэй, харгис, аймшигт хэрцгий дадал зуршлаа өөрчлөх цаг болжээ. Эдений цэцэрлэгийн үлгэрээр бол бидний анхдагч хүнс нь веган хоол (ургамал хоол). Ийм хүнс л бие махбод, сэтгэхүй, сүнсний тэнцвэрт байдлыг дэмждэг. Бид зөвхөн ургамлын хүнс хэрэглэн аз жаргалтай, эрүүл саруул амьдрах боломжтой. Олон нэртэй жүжигчин, тамирчин, тулааны урлагийн мастер, анагаах ухааны эмч, эрдэмтэн, Нобелийн шагналтан ургамлын гаралтай хүнсний ач холбогдлын амьд үлгэр дуурайл болж байна. Ингэснээр мөн “Аллага бүү үйлд” “Ахимса” буюу харгислал бүү үйлд гэсэн зарчмыг мөрдөж байна. Амьтдыг идэх нь Бурханы сахилыг зөрчиж байгаа хэрэг юм. Хэдийгээр зарим хүн өөрөө аллага үйлдээгүй ч бусдыг аллага үйлдэхэд хүргэж байгаа учраас аллага үйлдсэнтэй адил. Бидний хоолны төлөө амьтдыг харгислан хөнөөж байна, гэтэл үүнийг төрөл бүрийн ургамлын гаралтай хүнсээр орлуулж болох билээ. Орчин цагт энэ нь бүр ч хялбар болсон. Амьтдыг хороосноос болж бидний сүнс, бидний мөн чанар гэмгүй нэгний цусанд нэвчиж

байна. Ариун Гэгээн, Хүндэт Таныг дагаж дуурайдаг, танаас үлгэр дуурайлал авдаг, таныг энэрэл нигүүлсэл, хайрын бэлгэдэл хэмээн дээдэлдэг итгэгч дагалдагч нартаа үүнийг ахин дахин зааж сургаарай. Тэд та нарыг сонсоно! САТАН, МААЯА, ЧӨТГӨР, СӨРӨГ ХҮЧНҮҮД БИДНИЙГ УДИРДАЖ, БУРХАНЫ ТААЛЛЫН ЭСРЭГ, бидний төрөлхийн ухамсар, нигүүлсэнгүй мөн чанарын эсрэг ТӨӨРӨЛДҮҮЛЭХИЙГ ЗӨВШӨӨРЧ БОЛОХГҮЙ.

Энэ захидлаа үргэлжлүүлэхээсээ өмнө би дэлхийн томоохон шашны судруудад амьтны мах идэхийг хэрхэн хориглосон байдаг жишээнээс дурдъя. Хэн нэгэн нь сонсож байж магадгүй учраас, шашны сахилуудаа мартсан нэгэн сонсож байж мэдэх учраас уншиж өгье. Би цагаан толгойн дарааллаар уншъя.

БАХАЙН ШҮТЛЭГ

“Амьтадын мах идэх болон үүнээс цээрлэхүйн тухайд, бүтээлийн эхэн үед, Бурхан амьд амьтан болгоны идэх зүйлийг шийдэж өгсөн бөгөөд, үүнийг эсрэг зүйлийг зөвшөөрөөгүй гэдгийг та гарцаагүй мэдэж буй.”

~ Эрүүл мэнд, эмчилгээний тухай Бахайн бичвэрийн хэсгээс

БУДДЫН ШАШИН

“... ИДҮҮЛЖ БУЙ БҮХ МАХ НЬ ТЭДНИЙ ТӨРӨЛ САДАНГУУД
ЮМ.”

~ Ланкаватара Судар (Трипитака №671)

Шинээр хүүхэд мэндэлсний дараа ээжийг нь махаар хооллох гэж амьтны амь таслахаас болгоомжилж, мөн олон хамаатан саднаа цуглуулж, архи дарс ууж, мах идэхээс зайлсхийх ёстой... Учир нь төрөлтийн хүнд үед тоолшгүй олон ад зэтгэр, чөтгөр ороолон цусны үнэрээр цугларч идэхээр ирдэг... Харанхуй мунхаг, эсэргүү үйлдлээрээ махыг нь идэх гэж амьтны амь хороовол... өөрсдөдөө хараал авчрахаас гадна эх, нярай хоёрт аль алинд нь хор хөнөөлтэй.

~ Кситарба Судар, 8-р бүлэг

“Хүнийг өөд болсны дараах өдрүүдэд болгоомжтой байж, аллага үйлдэхгүй, устгаж сүйтгэхгүй, чөтгөр сахиуснуудыг шүтэж, тахил өргөн муу үйлийн үр тарихгүй байхад анхаарах хэрэгтэй, Учир нь ийм аллага үйлдэж, тийм зан үйл хийж, тахил өргөх нь өөд болсон хүндээ өчүүхэн ч түсгүйгээр барахгүй өмнөх үйлийн үр дээр нь бүр ч илүү нүгэлт үйлийн үр нэмж, илүү гүн, илүү ноцтой болгодог. ... тиймээс ТҮҮНИЙ САЙН ТӨРӨЛ АВАХ ХУГАЦААГ ХОЙШЛУУЛДАГ.” Эсвэл бүр шууд там руу илгээдэг.

~ Кситарба Судар, 7-р бүлэг

Үйлийн үр гэдэг нь төлөөс шийтгэл гэсэн утгатай. “Юу тарина, түүнийгээ л хураана.” Библид: “Юу тарина, түүнийгээ л хураана.” гэж бичсэн байдаг. Үйл үр гэдэг нь Самгарьдаар ийм утгатай.

“Хэрэв бхигшү* (лам) нар торгоор хийсэн хувцас өмсөхгүй,” хүр хорхойгоор хийсэн торго, “орон нутгийн арьс шир, үслэг эдлэл өмсөхгүй, сүү, цөцгий, цөцгийн тос идэхийг цээрлэдэг бол тэд үнэхээр гэтэлгэгдэх болно... Хүн бие сэтгэлээ хянаж, амьтны мах идэхийг цээрлэж, амьтны гаралтай бүтээгдэхүүн хэрэглэх, өмсөхөөс татгалзвал би түүнийг үнэхээр гэтэлгэгдэнэ хэмээн хэлж чадна.”

* Бхигшү – лам, хувраг.

~ Баатар явагч Их Хөлгөн Судар

“Хэрэв миний аль нэг шавь үүнийг сайтар тунгаалгүй мах идсээр байвал түүнийг кандела*-гийн угсааны хүн гэдгийг мэдэх хэрэгтэй. ТЭР МИНИЙ ШАВЬ БИШ, би түүний багш биш. Тийм учраас Махамати, хэн нэгэн хүн миний хамаатан болохыг хүсвэл ЯМАР Ч МАХ ИДЭХ УЧИРГҮЙ” гэжээ.”

* Кандела гэдэг нь алуурчин гэсэн утгатай.

~ Ланкаватара Судар

ЦАО ДАИЗМ

“Хамгийн чухал зүйл бол аллагаа зогсоох явдал юм. Учир нь амьтад бас сүнстэй бөгөөд хүн шиг ойлгодог... ХЭРЭВ БИД ТЭДНИЙГ АЛЖ ИДВЭЛ, ТЭДЭНД ЦУСАН ӨРТЭЙ БОЛНО.”

~ Гэгээнтнүүдийн сургаал, Арван сахил сахих тухай” – Аллагаас зайлсхийхүй, 2-р бүлэг

ХРИСТИЙН ШАШИН

“Ходоодонд нь мах маханд ходоод: Гэхдээ Бурхан хоёуланг нь бас тэднийг устгах болно.”

~ 1-р Коринтианчууд 6:13, Ариун Библи

“Мах аманд нь орж дөнгөж зажлагдаж байхад хүмүүсийн эсрэг Бурханы уур хилэн дүрэлзэн асаж, Бурхан хүн төрөлхтнийг маш их гай гамшигт автуулжээ.”

~ Ной мер 11:33, Ариун Библи

КҮНЗИЙН ШАШИН

Бүх хүнд бусдын зовлонг хараад тэсэн тэвчдэггүй оюун ухаан байдаг.”

~ Мэнсиус, Гон Сан Чоу, 6-р бүлэг

“Амьтдыг амьд байхыг нь харсан хүн үхэхийг нь харж чаддаггүй, шаналж үхэхийг нь сонссон бол МАХЫГ НЬ ИДЭЖ ЗҮРХЭЛДЭГГҮЙ.”

~ Мэнсиус, Лианы Кин Хүй, 4-р бүлэг

ДАО ДУАИЗМ

“Энх тайвныг тогтоохын тулд хүн төрөлхтөн эхлээд амьтдыг алж өөрсдийгөө тэжээхээ зогсоож, тэднийг амар тайван орхих ёстой, тэгсэн цагт хүмүүсийн дунд энх тайван цогцолно.”

~ Нам Күок Пат Хийд

ЭССЭНЧҮҮД

Би цустай золиос, цустай баярыг зогсоох гэж ирлээ, хэрэв та нар амьтны мах цусаар тахил өргөж, идэхээ зогсоохгүй

бол Бурханы хараал та нараас хэзээ ч холдохгүй.”

~ Ариун Арван Хоёрын номлол

ХИНДҮИЗМ

“Үхсэн амьтдыг буцаагаад амьдруулж чадахгүйгээс хойш тэднийг алсан хариуцлагаа та үүрнэ. Тийм учраас та там руу явах болно, ямар ч аврал байхгүй.”

~ Ади-лила, 17-р бүлэг, 159-165-р бадаг

“Бусад амьтны махыг идэх замаар өөрийн махан биеийг тэжээсэн нэгэн ямар ч төрөл авсан бай хамаагүй зовлонт амьдралаар амьдрах болно.”

~ Махабхарата, Ану. 115.47.ФС, 90-р хуудас

“Дээдийн дээд минь ээ! Бусдыг гэмтээж хохироож олсон зүйлийг аливаа өлзийтэй үйлд ашиглаваас үр нь боловсрохын цагт, сөрөг үр дагавар авчирдаг.”

~ Дэви Бхагаватам, Дөрөвдүгээр дэвтэр, 4-р бүлэг, 32-р бадаг

ИСЛАМ

“Бусад төрөлтөнд өршөөл энэрэлтэй ханддаггүй хэнийг ч бай Аллах өршөөхгүй.”

~ Зөнч Мухаммед (Тэрээр амгалан байг), Хадит

“Гэдэс ходоодоо бүү амьтдын булш болго!”

~ Зөнч Мухаммед (Тэрээр амгалан байг), Хадит

ЖАЙНИЗМ

“АМЬД ТӨРӨЛТНҮҮДИЙН АМИЙГ ТАСЛАН байж өөрт нь бэлтгэсэн ХООЛ УНДЫГ жинхэнэ хувраг ХҮЛЭЭН АВАХ учиргүй.”

~ Сутракританга

ЖҮҮДЭИЗМ

“Ямар ч хүн, Изралийн иргэн, эсвэл холоос айлчилж яваа хүн гэх мэт, хэн ч бай амьтны цус идвэл: БИ ТҮҮНЭЭС НҮҮРЭЭ БУУРУУЛЖ ТЭР ЦУС* ИДСЭН СҮНСИЙГ харьяат улсаас нь таслах болно.”

*Энд Цус гэсэн нь цустай “махыг” хэлж буй.

~ Лэвителикүс 17:10, Ариун Библи

СИКХИЗМ

“Марихуан татаж, мах идэж, дарс уудаг эгэл хүмүүс ямар ч эргэл мөргөл үйлдэж, мацаг барьж, зан үйл үйлддэг байлаа ч, тэд бүгд там руу явна.”

~ Гүрү Грант Сахиб, 1377-р хуудас

ТАОИЗМ

“Ууланд очиж шувуудыг тороор бүү барь, усанд очиж загас, жараахай бүү хордуул. Үхэр бүү ал.”

~ Аниргүй зам мөрийн товхимол

ТҮВДИЙН БУДДИЗМ

“Амьд төрөлтнүүдийг алж махаар нь бурхан сахиусанд өргөл барих нь, эхэд нь хүүхдийнх нь махыг өргөж буйгаас өөрцгүй, энэ бол хамгийн аймшигтай нүгэл.”

~ Шавь байх дээд зам мөр: Гүрү нарын сахил, Арван гурван аймшигт нүгэл, Агуу Гүрү Гампопа

ЗОРОАСТРИАНИЗМ

“Ахура Мазда (Хурмаст тэнгэр) би сүсэгтэн олны хоол,

буянт үхрийн тэжээл болог гэж ургамлыг дэлхий рүү
бороо мэт асгасан билээ.”

~ *Авеста*

гэх мэт. Мэдээж, ахиад цаашаа маш олон бий. Энд цөөн
хэдэн жишээг л дурдлаа.

Дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл
SupremeMasterTV.com хаягаар зочлоорой.

Тэгэхлээр, хүн ямар шашинд харьяалагддагаас үл
хамааран хүн бүхэн “Аллага бүү үйлд” гэсэн хамгийн
чухал сахилыг сахих ёстой. “Ахимса”. Харгислал бүү үйлд.

Бурхан анх хүүхдүүдээ хэрхэн амьдраасай гэж хүссэн тэр
амьдралаар л хүн төрөлхтөн амьдрах цаг болсон. Нэр
төртэй, хүндтэй, энх тайванч, хайр энэрэлтэй байж, эх
дэлхийнхээ сайн харгалзагчид нь байх учиртай. Сүсэгтэн
олондоо энэ бүхнийг болон бусад зүйлийг сануулна уу. Та
бүхэн урьд нь хэлсэн гэдгийг мэдэж байна, гэвч, тэдэнд
ахин дахин давтан хэлж, энэ нь тэдний сүнс болоод эх
дэлхийд хамгаас чухал гэдгийг тайлбарлаарай. Бүхий л
амьтны зовлонг зогсоох цаг нь болсон, Бурханы анхны
хүсэл ёсоор тэд хайртай бүхэнтэйгээ байгальд амар
амгалан, эрх чөлөөтэй, сүр жавхлантайгаар амьдрах

эрхтэй.

Бурханы бүтээлийг аврахад нь туслаарай, гуйж байна. Ямар ч гэм үйлдээгүй төрөлтнүүдийн зовлонг таслан зогсооход туслаарай. Бид өөр хоорондоо дайтна, амьтадтай бас дайтна. Энэ бол буруу. Энэ нь зөвтгөж боломгүй үйлдэл. Энэ бүх үйлдэл нь Бурханы сахил хийгээд тааллын эсрэг үйлдэл. Сүсэгтэн олондоо сануулаарай. Эрхэм Гэгээнтнүүд, Хүндэт Та бүхнийг энэ аугаа их өөрчлөлтийг манлайлна гэдэгт итгэж байна. Бурханы сахилуудыг даган мөрдөж, хамаг төрөлтнүүдэд хайр, нигүүлсэл, хүндэтгэлтэйгээр хандахыг замчлах веган амьдралын хэв маягийг түгээн дэлгэрүүлэхэд манлайлна гэж итгэж байна. Та өөрийн алба хаагч, лам, гэлэнмаа, санваартан, итгэгч нартаа түгээгээрэй.

Танд итгэн олгосон энэ байр суурь, хүч чадал нь дэлхийн иргэдэд таны араас дагахаар тийм асар чухал, үр нөлөө бүхий урам зоригийг өгнө. “Энэ цаг үеийн баатар нь болоорой” гэж гуйж байна. Хэнд ч гэм хор хүргэдэггүй бидэнтэй зэрэгцэн оршдог амьтан гэж нэрлэдэг төрөлтнүүдийг авраач гэж гуйя. Тэд дэлхийг маань адисалж байдаг. Тэд маш гайхалтай төрөлтнүүд, тэд хүмүүст, өөрийн төрөл нэгт зэрэгцэн орших бусад амьтандаа хайр энэрлээр

ханддаг. Манай Суприм Мастер Телевизээр дэлхийн өнцөг булан бүрээс бидэнд бичиж явуулсан, амьтдын хайр, нигүүлсэл, найрсаг занг харуулсан бичлэг олон бий. Сүсэгтэн олондоо түүнийг үзээрэй гэж захиарай. Бид өөрсдөө тамыг бүтээж, Бурханы хайртай бүтээлийг үй олноор нь хэрцгийлэн хөнөөж байгаа тамын үйлдлийг үл тоомсорлосон мөртлөө Диваажинд очно гэж хүлээх хэрэггүй. Бурханы бүтээлийг сүйтгэхээд, Бурханы бусад хүүхдэд буюу амьтанд ямар ч өршөөл хайр хүртээдэггүй атлаа Диваажингийн тус дэмийг хүртэнэ гэж хүлээх хэрэггүй.

Тэдний туулж буй энэ аймшигт зовлонд битгий харалган хандагтун. Бурхан тэдний өдөр тутамдаа туулж байгаа шаналлыг мэдэж байгаа. Диваажин хийгээд Газар дэлхий тэдний зовлонг гэрчилнэ. Тэдний тэсэшгүй бэрх зовлондоо хашхиран уйлах дуу бүх Диваажинг доргиож, олон төрөлтний зүрхийг өвтгөж байна. Тэдний төлөө дуу хоолойгоо өргөгтүн, тэдэнд туслагтун, ингэснээр хурдацтай өрнөж байгаа уур амьсгалын өөрчлөлт намжиж, дэлхий эрүүлжинэ. Таны эрхэм ариун үйл хэрэг Диваажингийн бүртгэлд үүрд үлдэж, манай гараг дэлхийн эерэг зөөлөн уур амьсгалд, дэлхийн энх

тайванд, уур амьсгалын өөрчлөлтийг зогсооход хувь нэмрээ лавтайяа оруулна. Энэ бол дэлхийн амьтай бүхэнд чухал үйл хэрэг. Бүхий л амьд оршихуй Таны энэрэнгүй үйлд найдлага тавьсаар байна.

Дэлхийн иргэд, амьтад, хүүхдүүд Таны баатарлаг, нигүүлсэнгүй үйл хэргийг үүрд санан дурсаж, Бурханы нэрийг дуудан Таныг аз жаргалтай, элбэг хангалуун, эрүүл саруул урт наслахыг гуйн залбирах болно. Бүхнийг өршөөгч Диваажинд талархах болно. Бүхнийг хайрладаг Бурхан хэрвээ бид хайраар бялхаж, элгэсүү дотно амьтан анд нарынхаа амийг хэлтрүүлэн тэдний амьдралыг хүндэлбэл бидний нүглийг өршөөж, насыг уртасгана.

Таныг Бурхан ивээх болтугай, Бурхан бүхий л Гэгээнтэн, Эрхэм Хүндэт Шашны удирдагч та бүхний ариун үйлийг элбэг дэлбэгээр адислаж, эх дэлхийг маань адислах болтугай.

Амен. Танд Баярлалаа. Танд Баярлалаа, Танд баярлалаа.

Бурханы Хайрын хамт, баярлалаа.²⁰

7 Дэлхийн бүх улс орны төр засгийн удирдагч, Засгийн газарт яаралтай хүргэх Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн захидал



Эрхэм Хүндэт Төрийн Тэргүүн, засгийн газрын алба хаагчид та бүхэн өнөөдрийг хүртэл цагдлынхаа хэрээр дэлхийдээ тусалж байгааг би үнээ талархаж байна. Бүгдэд нь баярлалаа. Та бүхэн юу хийвэл хамгийн зөв бэ гэдгийг аль хэдийн мэдэж байгаа болохоор би зүгээр л сануулах гэсэн юм. Та удирдлагад тань байгаа ард иргэдээ төдийгүй бас бидэнтэй зэрэгцэн амьдарч байгаа амьтан төрөлтнүүдийгээ ч бас хамгаалах үүрэгтэй юм шүү. Тэд маань үнэхээр өрөвдөөр, хүмүүсийн гарыг л харж амьдардаг. Үүнийг хэлэхэд хрилэг энэрэнгүй АМАТА ТЭЖ БАЙДАТҮЙ, гэм зэмгүй төрөлтнүүдийг хууль ёсоор ална гэж бүр ч байдаггүй. ДЭЛХИЙ МААНАБ МАТАЖ БАЙНА, байдал юу юугүй л улам дордсоор байна, хүн төрөлтөн, амьтны үхэл осол хүрдтэй өсөж байна. Диваажин болоод газар дэлхий хүн төрөлтийг цоо шинэ, хагин жигтэй өвчнүүдээр шийтгэж



байна. Хаа сайгүй аюулт дохио илхэн харагдаж байна. АНХААРЧУЛТБИГ ДОХИО Мар гэрлээр асаж, дэлхийн хаа сайгүй ил гарт байна! Цур амьсгалын өөрчлөлт хурдацтай тэлсээр байна. Мал амьтан үржүүлэх, загас, өндөг, сүүний үйлдвэрлэл гээд амьтадтай холбоотой юу ч бай дэлхийг дулааруулж байгаа үхлийн хорт метан хийг ялгаруулдаг. Тэгэхлээр энэ харис хэрцүү аглагын бизнесээ зогсоох нь дэлхийгээ сэргүүрлэх хамгийн хурдан арга зам юм. Танд энэ бүхнийг зогсоох хүч бий. ВЕТАН ХҮҮЛБ ТАРТАЖ. АМ67D6IT ЗОВООЦОЖ АМБАА БУЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААТ ЗОТЦООХ эрх таны гарт бий. Бүх төрөлтөнд, хүн болон амьтанг зовлон үрүүрлахыг зогсоох эрх танд бий. Нинжин сэтгэлээс нинжин сэтгэл төрж, нигүүлслэлээс нигүүлслэл дэлгэрдэг. Өршөөөл Диваажингийн өршөөлийг хүртэнэ. ВЕТАН ХҮҮЛБ #6 ЭХ ДЭЛХИЙТЭЭ АБРАХ ХАМТИЙН ҮР ДҮНГЭЙ АРТА ЮМ. Тиймтээ гарцаагүй энэ шийдвэрийг гаргаахаасаа бүр зайлсхийгээрэй. ВЕТАН ХҮҮЛБ ТАРТААД ТАРБИГ ҮСЭЭ ЗҮРНИХ, түүн атархан. Зөв сонголт хийхэд хүяцаа байгаа гээд шийдвэрээ гаргаарай, харамсахаг ч



оройтохоосоо өмнө амжиж хийгээрэй. Бурхан бидэнд дахин хилэгнэж, улам их галшигтай цаг агаар, цар тахал, илүү айдас хүйдэс илгээх, дахин хүн амь насаа алдаж, үнэт нооц баялаг цусах, санхүүгийн хямралд нэрвэгдэхээс өмнө үүнийг хийгээрэй. Бурханы төлөө, Бурхантай хамт ажилла. **Та ОДОО ЗӨВ ЗҮЙЛМҮЙТ ХҮЙСНЭЭРЭЭ** сэтгэл хөнгөн, эрхэм ариун, аз жаргалтай үлдэх болно. **Эх дэлхийгээ аврахын тулд ВЕТАН ХҮҮЛБ гаргаж, ВЕТАНУЗМБИТ ХҮҮЛБ БОЛТООРОЙ.**

Энэ бол дэлхийн бүх улс орны төрийн тэргүүн, Засгийн газарт хүргэх нээлттэй захидал юм. Юуны өмнө та бүхэн нийтэд үйлчлэн олон зүйл дээр ард иргэддээ хүргэх үйлчилгээний стандартаа дээшлүүлэхийн тулд хувийн амьдралаа хойш нь тавьж, тогтмол бус, урт цагаар ажиллаж, хувийн аз жаргалаа огоорч, эрүүл мэнд, үнэт цагаа зориулдаг ч заримдаа шүүмжлүүлэн ажиллаж байдаг тань талархаж буйгаа илэрхийлье. Ялангуяа байгаа нөөц бололцоондоо түшиглэн аль чадлаараа улс орныхоо сайн удирдагч байхыг хичээж буй төрийн удирдагч, сайд, засгийн газрын бусад өндөр алба тушаалтан та бүхэнд талархаж байна. Үзэгдэх болон үл үзэгдэх хэлбэрээр би та нарт тусалж байгаа шүү. Би та бүхний ажлыг оюун ухаан болон сүнслэг төвшинд тусалж дэмжиж байгаа. Энэ захидлыг та бүхний асууж илгээсэн зарим нэг асуултад хариу болгохын хамт бас түрүүчийн илгээсэн захидлуудад магадгүй тийм ч их тодорхой бүс илэрхийлсэн санаагаа тодруулах зорилгоор шууд ТВ-ээр дамжуулж байна. Хамгаас чухал хариулт бол хүнлэг аллага гэж байдаггүй гэдгийг л хэлэхийг хүссэн юм, мөн бид амьтны амь таслахыг БҮРМӨСӨН ЗОГСООХ, амьтны гаралтай бүтээгдэхүүнээс бүрэн татгалзах ёстой.

Хүндэт төрийн тэргүүн, Засгийн газрын алба хаагчид та

бүхэндээ, ялангуяа хаад, хатад, ханхүү, гүнж, ерөнхий сайд, ерөнхийлөгч, мэргэжлийн олон салбарыг толгойлж байгаа сайд нарт өнөөдрийг хүртэл эх дэлхийдээ туслахын тулд хамаг чадлаараа хичээн ажиллаж байгаад нь гүнээ талархаж байна. Би бүх хүнд талархаж байна. Дэлхийн бүх иргэний нэрийн өмнөөс та бүхний хийсэн бүхэнд талархъя. Төрөл бүрийн зан араншин, үзэл бодолтой нүүр түлж ажиллах удирдагчийн алба амаргүй. Та бүхэн чухам юу хийвэл зөв болох вэ гэдгийг аль хэдийн мэдэж байгаа учраас миний энэ хэлэх зүйл бол ердөө л сануулга төдий юм. Та бүхэн юу болохыг сайн мэдэж байгаа, тийм шүү, та бүхэн ухаалаг хүмүүс учраас удирдагчаар сонгогдож, тусламж хэрэгтэй газар, хэрэгтэй хэн нэгэнд гараа сунгаж, тэр дундаа бидэнтэй зэрэгцэн орших амьтан анд нартаа туслах үүрэг хүлээн сонгогдсон билээ. Та бүхэн юу хийхээ мэдэж байгаа. Зүрх сэтгэлийнхээ гүндээ юу хийхээ мэдэж байгаа, дэлхийн төлөө юу хийвэл зөв гэдгийг мэднэ. Диваажингаас дэлхий дээр шударга ёсыг төлөөлж, Бурханы хүүхдүүдийг харж хамгаалах үүрэг хариуцлагыг та бүхэнд хүлээлгэсэн. Үүнийгээ зөв хийхгүй бол хүлээх хариуцлага төлөөсийг ч та бүхэн мэдэж байгаа. Та бүхний халамж удирдлага дор байгаа ард иргэд төдийгүй бидэнтэй зэрэгцэн оршиж байгаа амьтдыг ч бас хамгаалах ёстой. Тэд тун өрөвдмөөр, хүмүүсийг гарыг л харж байна.

Би та бүгдэд, Засгийн газарт ажилладаг бүх хүнд хандаж олон захидал бичсэн. Олон хүн хариу илгээсэн. Та нарын зарим нь олон асуулт асуусан, хүн бүхэн харилцан адилгүй асуулт тавьсан. Зарим нь магадгүй, энэ талаар бодож тунгаахад хугацаа хэрэгтэй байсан учраас тэгсэн байх, хариу ирүүлээгүй байгаа. Энэ үнэхээр зүрх шимширмээр байгаа биш үү? Амьтдын шаналан уйлахыг би сонсдог байтал та нар яагаад сонсохгүй байна вэ? Та бүхэнд хамгаалалт олон бий, эрүүл мэндээ хамгаалуулна гэх мэт... Ядуу иргэдийн хамгаалалт бага – ихэнх нь өөрийгөө хамгаалах чадваргүй. Харин амьтдад бол бүр дуу хоолой ч байхгүй, сонголт ч байхгүй, тэднийг хамгаалах хуульч ч байхгүй. Диваажин луу хандан биднийг, бас амьтдыг өршөө гэж залбираарай. Тэдний оронд өөрийгөө тавиад үз, ямар ч өршөөлгүйгээр шуудхан л харгислалын золиос болдог. Магадгүй та бүхэн энэ тухай бодож байгаа байх? Энэ дэлхийд, бүхий л төрөлтнүүдэд илгээсэн тусламж бүрийнх нь төлөө Диваажинд талархацгаая. Амен.

Амьтад сүнстэй, билиг ухаантай, мэдлэгтэй, зарим нь бүр үзэгдэх болон үл үзэгдэх ид шидийн хүчтэй. Заримдаа бид үүнийг нь харж чаддаг, тэр нь үнэхээр гайхалтай. Нэгэн түүх ярьж өгье. Би алс хол оршдог нэгэн уулархаг нутагт амьдардаг. Миний байгаа газар хэдэн сармагчин гүүлдэж ирээд нэг төрлийн үндэс ухаж аваад идэж байв. Би тэдэнд

жаахан хоол өгөхөөр тэд үргэлж “баярлалаа” гэж надад талархдаг. Би тэдэнд “Диваажинд таларх. Би энэ бэлгийг дамжуулж байгаа төдий юм. Бурханд таларх.” гэж хэлдэг. Тэд намайг харах бүртээ үргэлж “Танд сайн сайхныг ерөөе” гэж, “Вүү! Вүү!” буюу “Сайн сайхныг ерөөе” гэж мэндчилдэг. Баярлалаа гэдгийг “Ээр” гэдэг. Би байнга тэднийг ирж идэхийг нь хүлээгээд байж чадахгүй учраас идэх юм гадаа орхиод ордог юм. Тэд идэж дууссанахаа дараа заавал намайг гарч ирэхийг хүлээнэ. Сармагчны хаан нь намайг гарч ирэхийг, эсвэл цонхоороо цухуйхыг хүлээж байгаад “Ээр!” гэж хэлчхээд явдаг. Надад тусалсан амьтдын тухай түүх, ухаантай гэдгийг нь мэдэрсэн олон түүх байгаа ч тэр бүхнийг энд ярих цаг зав алга. Амь насыг минь аварсан аалзны тухай ахиад нэг түүх ярьж өгье. Аалз. Тэр их аалз маш том байсан, миний гарын алганы хэмжээтэй аалз. Бараг л дэлгэсэн алганы дайтай. Нэг өдөр өглөөний хоёр цагийн үед би бясалгаж байснаа гэнэт бослоо. Өдрийн тэмдэглэл дээрээ юм бичихээр босож ширээ рүүгээ ойртоод нэг том аалз байхыг харав, тэр ямар нэгэн зүйл анхааруулах гэсэн мэт хоёр дахь удаагаа ирсэн байв. Тэгээд би, “Өнөөдөр юу болоо вэ?” гэхэд тэр, “Гэрлээ битгий үнтраа. Буйдангаасаа хол бай.” гэсэн. Тэгэхээр нь би, “Яагаад тэр билээ?” гэж бодож байтал нэг могой мөлхөн орж ирээд яг миний сууж байсан газар ирэхийг харлаа. Би хүмүүс эрвээхэй барихдаа ашигладаг

тор шиг багаж ашиглан түүнийг гадаа гаргаж тавьсан. Бас могойг тийшээ мөлхөж ороход нь гадагш гаргасан. Тэр өдөр хортой могойноос амийг минь аварсанд түүнд би маш их талархсан. Өнгөөр нь болон толгойны гурвалжиндуу хэлбэрээр нь хортой могой байсныг мэдсэн юм. Сармагчны түүх үүнээсээ хавьгүй урт л даа, тэгэхдээ захидал маань хэтэрхий сунжирч магадгүй учраас ингээд амьтдын тухай түүхээ өндөрлөе. Би дараа шавь нартаа ярьж өгнө. Мөн хэрэмний тухай түүх бий. Ухаантай гэдгээ, сайн санаатай гэдгээ надад харуулсан амьтдын маш олон түүх бий. Үнэндээ би аалзнаас, “Та яагаад надад ийм сайн хандана вэ? Та надад хоёр удаа тусаллаа” гэж хэлэхэд тэр аалз, “Өө, яагаад гэвэл Та их сайхан сэтгэлтэй. Та биднийг хэзээ ч алж байгаагүй” гэж хэлсэн. Тэгэхэд нь би “Та нарыг алах аа? Би ийм зүйл бодож ч чадахгүй.” гэхэд тэр, “Зөвхөн аалз ч биш, Та гэрт тань орсон бүх шавжийг авардаг. Биднийг Та хэзээ ч алж байгаагүй. Тийм учраас бид бас Танд туслах ёстой.” гэсэн. Тэр тэгж л хэлсэн.

Амьтад гайхалтай. Телепатаар харилцах чадвараа бид хадгалж чадаагүй нь харамсалтай, хэл яриагүйгээр бүх төрөлтнүүд өөр хоорондоо харилцах боломжтой түгээмэл, бас маш тохиромжтой хэл юм шүү дээ. Хүмүүс бид маш олон янзын хэлтэй, амьтад ч бас адилхан өөр өөрийн гэсэн хэлтэй учраас хэрвээ бид дотоодын хэлээрээ хэрхэн

харилцдагаа эргэн санавал илүү амар байхсан. Амьтад, модод хүртэл надад олон удаа тусалсан учраас би тэдэнд маш их өртэй. Дөнгөж саяхан л гэхэд дэлхийн энх тайвны тухай, амьтдын амар амгалангийн төлөө би олон яриа хэлэлцээр уулзалт хийж байгаа учраас сөрөг хүчний үлдэгдлүүд намайг их үймүүлж, төрөл бүрийн асуудал тарьдаг. Над руу шууд дайрч чадахгүй бол туслахуудад маань асуудал үүсгэнэ, эсвэл ямар нэгэн тааламжгүй үйл явдал болно. Зүгээр л миний цагийг үрэх гэж, эрчимтэй бясалгал даяандаа төвлөрөхийг сатааруулах гэж их оролддог.

Даяаны дундуур Бурхан надад үүнийг та бүхэнд бичээрэй гэж хэлсэн юм. Урьдын адил хүн нэг бүрд зориулаад бичээд байх цаг зав надад хомс байна. Тиймээс энэ захидлыг ТВ-ээр нэвтрүүлэн цацах юм. Магадгүй сонсох нь та бүгдэд илүү амар байх, яагаад гэвэл бүх асуултын хариулт адилхан: ВЕГАН ХҮНС, ВЕГАН ДЭЛХИЙ, зөвхөн энэ л зам манай гарагийг аварч, дэлхий дээрх бүх төрөлтөнд мөнхийн амар амгаланг авч ирнэ. Та нар юу хийхээ хэдийнээ мэдсэн гэж би найдаж байна. Энэрэнгүй веган дэлхийг бүтээхийн төлөөх жижигхэн алхмуудыг хай сайгүй хийсээр байгааг би харж байна. Ядаж л олон улс орон ядруу хөрш орнууддаа, зовж зүдэрсэн хүн зонд нь тусалж байгааг хараад би маш их талархдаг. Бурханд талархъя, та бүхнийг Бурхан

ивээг. Бидний дэлхий гарцаагүй их дээрдсэн. ГЭВЧ ОДОО БИДЭНД ХИЙХ ЁСТОЙ ДАХИН НЭГ АЛХАМ ҮЛДЭЭД БАЙНА: ВЕГАН АЛХАМ. Тэгвэл бүх зүйл төгс болохыг та харна. Бүгд энх амгалан болно. Хүн бүр тайвширч, аз жаргалтай байна. Одоогийнхоос илүү аз жаргалтай, улам амар амгалан болно. Диваажин шиг болчих боломжтой юм шүү дээ.

Гэвч та бүгд энэ тухай бодсоор л байгаа, веган хууль батлахын тулд юу хийх тухай тунгаасаар л байна, хүмүүст веган болж, мах, өндөг, сүү, загаснаас татгалз гэж яаж хэлэхээ бодсоор л байгаа. Мах гэж хэлэхдээ би загас гэхчлэн хөдөлдөг бүхий л төрөлтний махыг хэлж байгаа юм шүү. Өндөг хүртэл бидэнд муу, өндөг үйлдвэрлэлд маш их аллага хийгддэг. Ямар ч төрлийн мал амьтныг өсгөж үржүүлэх нь манай дэлхийн үүр амьсгалын өөрчлөлтийг улам дордуулна, яагаад гэвэл метаны хий болон эдийн засгийн өртөгтэй холбоотой төрөл бүрийн асуудлыг үүсгэдэг. Та бүхэн сайтар тунгаан бодож байгаа байх. Манай дэлхийн хамгийн хөнөөлт дайснаас яаж зайлсхийх вэ гэж та бүхэн ихэд хичээж байж мэднэ. Манай хүн төрөлтний статусыг доройтуулж, өдөр бүр олон тэрбум хүн, амьтныг үхэлд хүргэж байгаа, бас дахиад олон тэрбумаар нь тахир дутуу болгон үүнийгээ өдөр бүр үргэлжлүүлсээр байгаа тэр дайснаас зайлсхийж байж магад. Гэвч одоо бидэнд бодож байх хугацаа алга.

Гуйя, ХУРДАН ХЭРЭГЖҮҮЛЭЭРЭЙ. БИД ЭНЭ БҮХНИЙГ ЗОГСООХ ЁСТОЙ. Бид бол соёл иргэншилт төрөлтнүүд, ухаант төрөлтнүүд шүү дээ. 21-р зуунд амьдарч байна. Олон Их Багш ирж буцахдаа хамаг төрөлтөнд энэрэл нигүүлсэлтэй, эелдэг зөөлөн хандахыг зааж сургасан. Бусад төрөлтнийг, бас өөртэйгөө адил хүмүүсийг алж хядсаар байж болохгүй. Энэ бүхнийг зогсоох эрх мэдэл танд бий. ВЕГАН ХУУЛЬ ГАРГАЖ, АМЬТАН ЗОВООХТОЙ ХОЛБООТОЙ БИЗНЕСҮҮДИЙГ ЗОГСООХ давуу эрх та бүхэнд бий. Бүх төрөлтөн, хүн амьтанд зовлон шаналал учруулахыг зогсоох эрх танд бий. АМЬТДЫГ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛИУД ХАМГИЙН САЙН НЬ. АМЬТАН ХАМГААЛАХ ХУУЛЬ буюу ВЕГАН ХУУЛЬ нэвтрүүлж, амьтдад дахин хор хөнөөл, өвдөлт, айдас үүсгэхийг хориглох хэрэгтэй. Учир нь нинжин сэтгэлээс нинжин сэтгэл үүсэж, нигүүлслээс нигүүлсэл л дэлгэрдэг. Өршөөвөл Диваажингийн өршөөлийг хүртэнэ. “Юу тарина, түүнийгээ л хураана.” Библид ингэж бичсэн байдаг. Дэлхийн бүх том шашинд үүнийг сургадаг. Тиймээс ВЕГАН ХУУЛ ГАРГАХ НЬ ДЭЛХИЙГЭЭ АВРАХ ХАМГИЙН ҮР ДҮНТЭЙ АРГА.

НҮБ-ын анхааруулга, эрдэмтдийн судалгааны тайлангаас та бид бүгдээрээ мэдэж байгаа. Мах, загас, өндөг, сүү, лабораторид амьтад дээр туршилт хийх, арьс ширний үйлдвэрлэл гэх мэтчилэн зэрлэг, эсвэл гэрийн тэжээвэр

амьтан байна уу, ер хамаагүй ямарваа нэгэн АМЬТНЫГ ГЭМТЭЭЖ ӨВТГӨХТЭЙ ХОЛБООТОЙ бүхий л үйлдэл нь манай ДЭЛХИЙД ХОР ХӨНӨӨЛТЭЙ гэдгийг та мэднэ, бид ч бас мэднэ. Уур амьсгалын өөрчлөлтийг саармагжуулах тухай, агаарын бохирдлыг бууруулах тухай бид их ярьдаг, ГЭТЭЛ мал, амьтан өсгөж үржүүлэх, загас, өндөг, сүүний үйлдвэрлэл мэтийн амьтантай холбоотой үйл ажиллагаа бүхэн дэлхийн агаар мандлыг халааж байгаа хорт метан хийг маш ихээр ялгаруулж байна. Тиймээс энэ харгис аллагын бизнесээ зогсоох нь дэлхийг сэрүүцүүлэх хамгийн дөт арга зам юм.

Дашрамд хэлэхэд халим хэмээх далайн аварга том номхон дөлгөөхөн “загас” нь манай дэлхийн аврагч, хүчил төрөгчийн үйлдвэрлэгчид юм байна. Тэд CO2-ийг биедээ удаан хугацаагаар хадгалж, хамгийн багаар бодоход дэлхийн агаар мандал дахь хүчил төрөгчийн 50%-ийг ялгаруулдаг байна. Төсөөл дөө? Гэтэл зарим хүн шинжлэх ухааны судалгаа гэх мэтийн шалтаг гаргаж байгаад тэднийг идэхийн тулд агнаж байна! Далайд олон зуун мянган жил амьдарсаар ирсэн халимын юуг нь судлах гээд байгаа юм бол? Хэрэв болдог сон бол тэдэнд хүрэлгүй, тайван орхивол таарна, Бурхан тэднийг харж ханддаг. Би та нарт нэг тайлан уншиж өгье, Др. Ралф Чами, Др. Томас Козимано, Др. Коннел

Фүлленкэмп болон Сена Озтосун нарын гаргасан энэ тайланг Суприм Мастер Телевизийн Онцлох мэдээгээр 2019 оны 12 сарын 28-нд дамжуулсан. Та нарын мэдээлэлд зориулж хэлэхэд энэ тайлан нь “Уур амьсгалын өөрчлөлтийг шийдвэрлэхийн тулд халим загасыг яаралтай хамгаалалтад авахыг Олон Улсын Валютын Сангаас уриалж байна.” гэсэн нэртэй! Ямар ухаалаг шийдвэр вэ. “АНУ-ын эдийн засагчид агаар мандлаас нүүрстөрөгчийг шингээж авахад халим загас ямар үүрэг гүйцэтгэдгийг судалжээ. Олон Улсын Валютын Сангийн Санхүү болон Хөгжлийн тайланд халим амьдрах хугацаандаа 33 тонн нүүрстөрөгчийн хийг шингээж авдаг бол мод жилдээ хамгийн ихдээ 22 кг-ийг шингээдэг. Нүүрстөрөгчийн хийг халим биедээ хадгалдаг бөгөөд насан эцэслэсэн хойно нь олон зуун жилийн турш тэндээ үлдэж, агаар мандалд дэгддэггүй байна.” Халимын бие үргэлжлүүлэн хадгалсаар байдаг байна. Төсөөлж байна уу? Тэгэхлээр, Бурхан олон аврагч, сахиулсан тэнгэрсийг амьтдын дүрээр бидэнд туслуулахаар илгээжээ. Зүй нь халим байгалийнхаа жамаараа үхээд далайдаа үлддэг. “Түүнчлэн халимын амьдралын хэмнэл нь фитопланктоны өсөлтийг тэтгэдэг.” Давтан хэлэхэд “Халим фитопланктон бий болгосноор хамгийн багадаа агаар мандал дахь хүчилтөрөгчийн 50%-ийг ялгаруулж,

жилийн турш ялгардаг нийт нүүрстөрөгчийн 40%-ийг шингээж авдаг байна.” Дөчин хувь шүү. Халим жилдээ дэлхийн хэмжээнд ялгаруулдаг нүүрстөрөгчийн 40%-ийг биедээ шингээдэг байх нь. Төсөөл дөө. Гайхалтай. Нэгэн амьдралынхаа хугацаанд л тэр шүү дээ. Бүх халим тийм байдаг. Энэ нь тэдний зорилго. Би давтан хэлье, “Халим нь дэлхийн хэмжээнд жилдээ ялгаруулдаг нийт нүүрстөрөгчийн хийн 40%-ийг шингээж авдаг.” Халимнууд. Нягталж харж болох веб хуудсыг энд оруулъя.

<https://www.imf.org/external/pubs/ft/fandd/2019/12/natures-solution-to-climate-change-chami.htm>

Уур амьсгалын өөрчлөлт хурдсаж, дэлхий маань аюулд өртжээ. Гэвч та бүхэн минь нэг байрандаа эргэлдсээр, магадгүй юу хийх тухайгаа бодсоор байх шиг. Олон зүйл ярьдаг ч, хамгийн чухал сэдвээ хөндөхгүй юм. Олон асуудлыг барьж авч байгаа ч гол зүйлээ орхичих юм. Яг л зузаан оймсны гаднаас нь маажсан ч загатнасан газар хүрдэггүйтэй адил. Эрдэмтэд бидэнд XXXXX удаа, маш олон удаа, ахин дахин баримт харуулж анхааруулсан, дэлхийн дулаарлыг багасгаж, уур амьсгалын өөрчлөлтийг бууруулж, зогсоож, тэнцвэржүүлэхэд хамгийн үр дүнтэй, шилдэг арга бол веган хүнсэнд шилжих явдал гэдгийг

хэлсэн. Энэ нь дэлхий дээр амьдарч байгаа хүн, амьтан гээд ерөөсөө бүхий л түр оршин суугчдад нь чухал. Тийм ээ, бид дэлхий хэмээх энэ байшингийн түр оршин суугчид. Энэ гарагийг гэмтээх эрх бидэнд байхгүй, гэмтээвэл хатуу торгуультай.

Санаанд орж ирсэн үг бүхнийг жаахан эмх цэгцгүй л биччихлээ. Намайг өршөөгөөрэй. Зүрх минь шаналаад цэцэг навч дэлгэрэх адил гоё ганган үгээр бичих, эвсэл тойрч булзааруулан биччихвэл ойлгоход амаргүй болно. Бурхан гараас минь барьж сийрүүлэн зүрхнээс минь ВЕГАН-ДЭЛХИЙН төлөөх залбирал үндарч, дэлхийн дээрх бүхий л оршихүйн төлөө тэр бүхэн АМАР АМГАЛАН болохын төлөө залбирнам! Бурханд залбирч, өөрийн хувь нэмрээ оруулаарай. Та чадна, та бүхэнд дэлхийн ард иргэдийг зөв амьдралын зам мөрд хөтөлж, Диваажингийн таашаалыг хүртэн Газар дэлхий болон амьтай бүхний талархлыг хүртэх эрх мэдэл байна. Бид бүгдээрээ насанд хүрсэн, Бурханаас эмээдэг, хуулийг дээдэлдэг үнэнч иргэд. Тиймээс хуурамч зусардалт бялдүүчлал хэрэггүй. Таныг, таны эрдэм мэдлэгийг хүндэлж байна, тиймээс шударга үнэнээс өөр юуг ч би дурдахгүй. Түүнээс гадна Диваажингийн нүд биднийг нэвт харж байдаг, өдөр бүр дэлхийн өнцөг булан бүхэнд чимээгүйхэн зовж зүдэрч байдаг тэдний шаналлыг Диваажин, Газар дэлхий

гэрчилнэ.

Манай дэлхийн үхлийн тэргүүн шалтгаан нь мах гэдгийг бид бүгд мэднэ. Гэтэл ихэвчлэн Засгийн газрууд өөрснөө үүнийг нуун дарагдуулах гэж хамаг чадлаараа хичээж, олны анхаарлыг үр өгөөж багатай, эсвэл огт үр нөлөөгүй өөр сэдэв, үйл ажиллагаа руу чиглүүлж сарниулаад байх юм. Бид хүнлэг сэтгэлийн талд, Бурханы талд зогсох уу, эсвэл алуурчны талд зогсох уу гэдгээ өөрсдөөсөө асуух хэрэгтэй??? Өөрснөө хариултаа олоод нэн даруй ажил хэрэг болгоно уу. Бурханы, энэрэнгүй талд ажиллаарай, үгүй бол бид түүхэнд алуурчид гэдгээрээ үлдэнэ... Яагаад гэвэл үүний үр дагавар өнөөг хүртэл дэлхий дээр болсон дайн байлдааны аллагын нийлбэрээс ч хүнд байх болно. Та бүхэн оюунлаг учраас үүнийг мэдэж байгаа. Ухаантай учраас мэдэж байгаа. Тийм ээ! Удирдагчаар сонгогдсон учраас ухаантай л байж таарна, үүнийг хэрэгжүүлэх ухаантай л хүмүүс байгаа. Азийн зарим оронд удирдагчдаа, Засгийн газраа, “ард түмний эцэг, эх”. гэж нэрлэдэг. Та бүхнийг гомдоох зүйл хэлсэн бол чин сэтгэлээсээ хүлцэл өчье, гэвч хэлэхээс өөр аргагүй. Яагаад гэвэл амьтад, хүмүүс бүгд ялгаагүй устаж үгүй болох аюул нүүрлээд байна, ДЭЛХИЙ ШАТАЖ БАЙНА, юу юугүй улам дордсоор байна, ХҮМҮҮС, АМЬТДЫН амь нас ноцтой хэмжээгээр сүйдэж байна. Диваажин болоод

газар дэлхий хүмүүсийг цоо шинэ, бүр хачин жигтэй өвчнүүдээр сорьж байна. Сүйрлийн дохио хаа сайгүй илхэн харагдаад байна. АНХААРУУЛАХ ДОХИО ШАР гэрлээр асаж, дэлхийн хаа сайгүй илт байна!

Хэн нэгэн чанга дуугарах ёстой. Би илүү чанга дуугарах ёстой. Бүх Засгийн газар махны хэрэглээгээ багасгах протоколд гарын үсэг зурсан ч, үүнийхээ төлөө бодитой арга хэмжээ авахгүй байна. Ай хөөрхий! Бурхан минь энэ дэлхийд туслаач! Гэхдээ Бурхан биднийг дахин сонсох хүсэлгүй болсон байж ч магадгүй. Та нарын гар гэм зэмгүй төрөлтнүүдийн цусанд будагдсан учраас Тэр магадгүй бидний залбирлаас ч нүүр буруулсан байж мэднэ.

Би бидний олонхын мэдэх Библиэс нэг ишлэл хэлье. Исай, бүлэг 1:15. Бид бусад төрөлтнүүдээ үй олноор нь хөнөөсөн нүглээ цайруулж, амьдралын хэв маягаа өөрчлөхгүй бол Бурхан бидний залбирлыг сонсохыг хүсэхгүй. Яагаад бид Бурханы тааллын эсрэг зүйлс хийнэ вэ? Яагаад бид өөрсдийнхөө ухамсрын эсрэг зүйлс үйлддэг юм бэ? Ухаалаг төрөлтний ямар ч логик, учир шалтгааны эсрэг тийм зүйлсийг хийнэ вэ? Бид “Бүтээлийн Титэм” нь байх учиртай, Бурханы хүүхдүүд, ирээдүйн Будда нар шүү дээ.

Нэг хэлэхдээ бид амьтдад ямар нэгэн хор хөнөөл, өвдөлт зовуурь, айдас хүйдэс учруулахгүй байх тухай, тэднийг хамгаалах хууль гаргалаа гэх юм. Гэтэл нөгөө талдаа бид тэднийг үй олноор нь харгислан хядаж, амь тасрахаас нь өмнө үгээр илэрхийлэхийн аргагүйгээр өгүүлшгүй ихээр өвтгөж тамладаг. ИЙМ ЗӨРҮҮТЭЙ ҮЙЛДЛИЙГ БИ ЕР ОЙЛГОХГҮЙ ЮМ. Эсвэл магадгүй, тэднийг давчүү байранд шахаж, гинжилж, ариутгалын санд живүүлж, амьдаар нь хоолойг нь хэрчиж байгаагаа та энэрэнгүй дадал, тэднийг хамгаалсан үйлдэл гэж боддог юм уу? Энэ бүхэн чинь энэрэнгүй, бас хамгаалж байгаа үйл хэрэг гэж үү? Тэгээд үүнийг хуулиараа зөв гэх үү? Үнэндээ ХҮНЛЭГ АЛЛАГА гэх зүйл байдаггүй, гэм зэмгүй хөөрхий төрөлтнүүдийг үй олноор нь ингэж хөнөөх нь хууль бус явдал. Тэд бидэнд ямар ч гэм хор учруулаагүй. Тэд ямар ч гэмт хэрэг үйлдээгүй. Энэ бол шударга бус. Шударга ёс биш. Энэ тухай бодооч гэж гуйя, түргэхэн бодоорой. Бид харин ч эсрэгээр нь үйлдэх ёстой. ЯГ ОДОО ВЕГАН ХУУЛЬ ГАРГАЖ, АМЬТДЫГ ЗОВООСОН бүх төрлийн БҮТЭЭГДЭХҮҮНИЙГ ХОРИГЛОЁ. Маш энгийн, үнэхээр амархан. Хүн бүр одооноос эхлэн цус дусалсан зүсэм мах идэхээ л зогсоочих, амьтны гаралтай бүх бүтээгдэхүүнээс татгалз. Бүгдийг нь хоригло. ВЕГАН ХУУЛЬ ГАРГААД ГАРЫН ҮСГЭЭ Л ЗУРЧИХ. Амьтныг зовоож тамласан бүхий л

үйл ажиллагааг хоригло. Өөрсдийн үйлдсэн гэм нүглээ наманчилж, гараг дэлхийгээ аврахыг хүсвэл энэ бүхнийг хоригло. Тэгвэл Бурхан биднийг илүү их адислана. “Бурхан Өөртөө ямар ч амьтны тахил өргүүлэхийг хүсээгүй.” гэж Библид дурдсан байдаг. “Надад ахиж тахил бүү авчир. Надад дахиж амьтнаар бүү тахил өргө.” Тийм ээ. Библийн хаа нэгтээ бас ингэж бичсэн байдаг. “Залбирал үйлдэн гараа өргөхийг тань би харахгүй. Та хэчнээн олон удаа залбирлаа ч, таны гар гэм зэмгүй төрөлтнүүдийн цусанд будагдсан болохоор Би сонсохгүй.” гэсэн байдаг. Амьтад бол хохирогчид.

Би Азийн уламжлалыг даган цагаан түүз зүүсэн. Энэ нь гашуудлыг илэрхийлдэг. Надтай хамт гашуудна уу. Тоолшгүй олон эрин галавын өмнөөс, тоолшгүй олон мянган жилийн тэртээгээс хүмүүсийн гарт зовж, дайн дажин, хоол хүнсэнд нь зориулагдан хороогдож зүдэж шаналсан гэмгүй тэр сүнснүүдийн төлөө залбирч, гэтэлгэгдэхийг гуйгаарай. Зовлон шаналал, үй гашуу, үзэн ядалтаасаа гэтэлгэгдэхийг гуйн залбираарай. Өндөр дээд Диваажинд очиж амраг. Бурхан өөртөө ямар ч амьтнаар тахил өргүүлэхийг хүсэхгүй байтал бид тэднийг алж, цустай махыг нь идэхийг Тэр хүснэ гэж үү? Тиймээс гаргахаас өөр замгүй энэ шийдвэрээс ахин зугтах хэрэггүй. Сүүлийн үед хаа сайгүй маш олон амтлаг веган

хоол хүнс байдаг болсон. Хүмүүст болон бас бусдад зориулсан эрүүл саруул, аз жаргалтай хүнс. Веган хууль гаргах энэ шийдвэрийг бид хэдий чинээ эрт гаргах тусмаа л сайн, бидний ухамсарт сайн, энэ гараг дээрх бүгдэд сайн. Тэгснээрээ бид бас шүүлтээс аврагдана. Тиймээс төрөлх хайрын чанараараа үйлд. Нинжин сэтгэлт хүмүүс минь, Бурхан та бүхэнд дэлхийг асран хамгаалах хүч хайрласан. Та бүхэн түүнийгээ юунд ашиглаж байна вэ? Яг одоо хэрэгжүүлж, эх дэлхийгээ авраарай. ВЕГАН ХУУЛЬ ГАРГАН ГАРЫН ҮСЭГ ЗУРААД Л БОЛЛОО, түн энгийн. Зөв сонголт хийхэд дэндүү оройтохоос өмнө, харамсахад ч оройтохоор тэр мөчөөс өмнө амжаарай. Бурханы уур хилэн дахин буухаас өмнө, хэцүү бэрх цаг агаар, халдвар тахал, айдас хүйдэс, дахин олон хүний амь сүйдэж, үнэт нөөц баялаг устаж, санхүүгийн гамшиг нүүрлэхээс өмнө амжиж арга хэмжээ аваарай. Эрт дээр үед Давид Хаан нэг л хүний амийг хэлмэгдүүлэн хороосноосоо болж ард иргэд нь гурван өдрийн түрш цар тахалд нэрвэгдэн шийтгүүлсэн. Энэ цаг үед цар тахал үүрдийнх мэт ар араасаа цувсаар байна, бидэнд зугтах газар алга?

Амьтны махыг идсэнээс үүдсэн үхлийн аюултай тахал / цар тахлууд

ДОХ – шимпанзегас халдварласан

Крейзфелд-Жакоб өвчний хувилбар (Үхрийн галзуу өвчин) – үхрээс халдварласан

H5N1 Шувууны ханиад – тахиа, галуунаас халдварласан

SARS (Амьсгалын замын цочмог хам шинж) – суусраас халдварласан

H1N1 Гахайн Ханиад – Гахайнаас халдварласан

MERS (Ойрх Дорнодын амьсгалын замын хам шинж) – тэмээнээс халдварласан

Эбола – сарьсан багваахайнаас халдварласан

КОВИД-19 – сарьсан багваахай болон панголиноос халдварласан

Энэ бүх өвчин АМЬТНААС ХҮНД халдварладаг байна.

Бид өөр хаашаа нүүх вэ? Бидэнд нэг л гараг бий. Дээр нь хээрийн аймшигт түймэр, хар салхи, газар хөдлөлт, цунами гэх мэт гамшиг зай завсар өгөхгүй түйвээж байна. Дэлхий дээр түр оршин суугаа ч өөрсөдтэйгөө адил хүмүүсийг, амьтдыг ямар аймшигтайгаар харгисалж буйг хараад Диваажин, бас Газар дэлхий цөмийн гүнээсээ

чичирхийлж байна. Тиймээс төрөл бүрийн гамшиг тохиох нь гарцаагүй. Хамгийн сүүлийн Уханий цар тахлаар амь насаа алдсан хүмүүсийн тоо нэмэгдсээр, олон сая хүн хөл хорионд байна. Олон нийт сандарч, эмх замбараагүй байдал үүсэхээс сэргийлж, бас эдийн засагт үзүүлэх нөлөөнөөс айсандаа зарим Засгийн газар амь үрэгдсэн, хөл хорионд орсон хүмүүсийн тоог багасган хэлж байна. Та нар бүгд үүнийг мэдэж байгаа гэдэгт итгэлтэй байна. Нүдээ нээ, оюун ухаанаа нээ, зүрх сэтгэлээ нээ, эргэн тойрондоо болж байгаа бодит байдлыг сайн ажигла. Бурханаас хайрласан давуу эрхт байр суурь, хүч чадлаа дэлхийг зөв замд нь оруулахад ашигла. Энэ дэлхий дээр байгаа бүгдийг харж хандаг гэж, зөв чиглүүлэг гэж, Дэлхийн сайн асран хамгаалагч нь байг гэж энэ өндөр алба тушаалд таныг томилсон. Тиймээс цаг хугацааг, Бурханы адислалыг дахин дэмий үрэхээ боль. Нөхцөл байдал хяналтаас гарахаас өмнө яг одоо хий, өөрчил, эргэлзэх хэрэггүй. Гай гамшиг гэнэт бүүвал бидэнд хариу үйлдэл хийх цаг гарахгүй. Та бүхэнтэйгээ хамт би залбирсаар байна, хайрын сэтгэлээр хүмүүс бидэнтэй нэгдэн залбирсаар байна. Бурхантай хамт, Бурханы талд ажилла. Та илүү хүчтэй, аз жаргалтай байж, бие, хэл, сэтгэлээрээ тайвширч, зүрх сэтгэлийн тань доторх гэмшил аажмаар арилах болно. ЯГ ОДОО ТЭР ЗӨВ

ЗҮЙЛИЙГ ХИЙСНЭЭР та хөнгөн, ариун, аз жаргалтай тэр мэдрэмжийг хүртэнэ. Эх дэлхийгээ аврахын тулд ВЕГАН ХУУЛЬ гарган ВЕГАНИЗМЫГ ХУУЛЬ БОЛГООРОЙ.

Бурхан ямар ч төрөлтнийг зовоосой гэж хүсдэггүй. Амьтны, эсвэл өөр ямар ч төрөлтний мах цусыг хүсдэггүй. Хөвч хөндөхийг ч хүсдэггүй. Яах гэж? Хөөрхий нялхсыг тэгж зовоож үхүүллээ гээд Бурханд ямар тустай гэж? Энэ зан үйлийг хийж эхэлснээс хойш төрөөд хэдхэн хонож буй тоолшгүй олон нялхас зовж үхсэн. Мэс ажилбарын дараах хор үршгаас л болж шүү дээ. Цус алдах юм уу, халдвар авснаасаа болж нас барж байна. Эцэг, эхийнх нь үй гашууг төсөөлөөд үз дээ. Тэгээд Бурханд ямар санагдахыг төсөөлж чадах нь уу? Бид Бурханыг бас зовооно. Учир нь Бурхан биднийг Өөрийнхөө дүрээр бүтээсэн. Бид бол Бурханы хүүхдүүд. Хүүхдүүд нь зовоход Бурхан ч зовдог. Ингэх нь Түүний хүсэл огтхон ч биш гэдгийг Бурхан надад хэлсэн. Ариун сэтгэлтэй, эмзэг итгэгч сүсэгтнүүдийг зовоох гэж хуурамчаар Бурханы нэрийг барьсан Сатан чөтгөр л ийм зүйлийг хийсэн. Улс орноо хүчирхэгжүүлж, хүн амаа өсгөж, хөгжил цэцэглэлд дагуулах эрэгтэй залгамж халааг олноор нь хөнөөх гэж, тэднийг зовлонд унагах гэж л ийм зүйл сэдэж олсон. Бодоод үз дээ, хөөрхий гэмгүй нялхсыг, хүүхдүүдийг,

эцэг, эхийг нь ямар гэгчийн Бурхан өвтгөж зовоохыг хүсэх вэ? Яах гэж эцэг, эхийнх нь санааг зовоож, сэтгэлийг нь өвтгөнө гэж? Тэд ч бас Түүний хүүхдүүд. Хэдийгээр тэд миний хүүхдүүд биш ч, би аав, ээж нь биш ч гэлээ зүрх сэтгэл минь тэдний туулж байгаа өвдөлт зовуурь, зовлон шаналлыг мэдрэн маш их шаналдаг, ялангуяа хөөрхий азгүй нялхсын төлөө би ингэж шимширч байхад бүхнийг-Хайрлагч Бурхан яаж үүнийг тэсвэрлэх билээ. Тэр тийм тушаал өгсөн эсэх талаар ярихын ч хэрэггүй. Олон сая жилийн өмнөөс санаатай болон санамсаргүйгээр хүмүүсийн гарт үрэгдэж, тамлуулсан тоолшгүй олон гэм зэмгүй төрөлтнүүдээс би Хамгаас шударга өршөөлт Бурханы нэрийн өмнөөс өршөөж уучлахыг гуйж байна. Одоо 21-р зуунд бид илүү иргэншсэн байх учиртай сан. Мүхар сүсэг, харгис уламжлалаа зогсоох ёстой сон. Гэмгүй нялхас, амьтад, хүмүүст хор уршиг учруулахаа болих ёстой. Сатан чөтгөр л хамаг төрөлтнийг зовоох элдэв зүйл санаачилдаг. Түүний тамын арга. Тэр бол там. Тэр зовлон зүдүүр, үй гашуу, өвдөлт шаналал гээд муу, сөрөг, хар бараан бүхний бэлгэдэл. Тиймээс гэм зэмгүй, гэнэн хонгор үрсээ хамгаалаарай. Чөтгөр яагаад эр хүйст нялх үрсийг, нуган үрсийг, эсвэл эрчүүдийг зовоохыг хүсдэг болохыг хэлж өгье. Яагаад гэдгийг нь хэлье л дээ.

Өршөөлт Бурхан ийм зүйл хэлээгүй гэж Бурхан надад хэлсэн. Сувдаг чөтгөрүүд, Сатаны туслахуудын үйлдсэн үйл аж. Тэд дайн дажин, сөргөлдөөн тэмцэл, өвчин зовлон гэх мэтэд амь насаа алдсан төрөлтнүүдийн махыг идэх дуртай. Саяхнаас тэд миний тэвчээрийг барж, хэт их үймүүлсэн учраас чөтгөрүүдийн 80 хувийг аль хэдийн Анхдагч Ертөнцийн Бурхад, Хамгаалагчид там руу чирч аваачсан. Учир нь ийм төрлийн чөтгөрүүд хэдийгээр өөрсдөө Сатан биш ч гэлээ Сатаны талд ажиллаж, хүмүүсийн дунд, эсвэл хүмүүс болон амьтдын хооронд, эсхүл амьтдыг хооронд нь, бүх төрөлтнүүдийн хооронд үзэн ядалтыг өдөөж, тэднээс ялгаран гарсан энергиэр хооллодог. Тэд ингэж л амьдардаг, тэдний зовлонгоор, үхсэний нь дараа махаар нь бас хооллодог. Тэд надад ингэж хэлсэн. Сувдаг чөтгөрүүд (хий үзэгдлүүд) надад дэлхийд энх тайван тогтвол идэх юмгүй болох учраас энх тайвныг бүү тогтоо гэж хэлсэн. Би, “Та нарын хүслийг биелүүлж чадахгүй нь. Та нар намайг дагаж, гэртээ харь, Диваажинд хүрч болно. Би тийм л зүйлийг амлаж чадна. Энэ гараг дэлхий дээр хүн амьтныг цаашид зовоосоор байхыг би зөвшөөрөхгүй. Хангалттай. Аль хэдийн хангалттай болчихсон!” гэж хэлсэн. Тэд өөр юм идэж чадахгүй гэсэн. Би тэднээс, “Та нар жам ёсоороо үхсэн амьтдыг юм уу, орхиж хаясан цогцос мэтийг идэж болдоггүй юм уу?” гэж асуухад тэд үгүй, өөр энергитэй

байдаг учраас болохгүй гэсэн. Зовж зүдэрсэн, үзэн ядсан, гашуудаж гуньсан, эсвэл айж эмээсэн төрөлтнүүдийн, айж түгшиж үхсэн цогцсын махыг идэх шаардлагатай юм гэнэ ээ. Бусад мах өөр энергитэй учраас тэд иддэггүй аж. Би, “За, та нар өөрчлөгдөх ёстой. Та нарыг идшээ бэлдэж, дайн тулаан дэгдээгээд байхыг цаашид хараад байж чадахгүй.” гэж хэлсэн. Зовж шаналсан, айдсын энергитэй махнаас өчүүхэн жаахныг идэхэд л тэд удаан хугацааны турш цатгалан байдаг гэнэ. Би, “Юу ч боллоо гэсэн би та нарын хүслийг зөвшөөрч чадахгүй, ийм үйлдлийг зөвшөөрөхгүй. Би хүмүүст хайртай, амьтдад хайртай. Санамсаргүй тохиолдлоор энэ гараг дээр гацаж үлдсэн бүх сүнс гэм буруугүй. Би тэдний зовохыг дахиад зүгээр хараад сууж чадахгүй. Тиймээс хамгийн сайн шийдэл бол та нар намайг дагаж, гэртээ харих явдал.” гэж хэлсэн. Зарим нь тэгсэн, гэхдээ тун цөөхөн. Үнэндээ өнөөдрийн байдлаар энэ чөтгөрүүдийн 82 хувийг аль хэдийн чирээд тамд авааччихсан. Тэд намайг үймүүлсэн учраас надад тэгэх шалтаг байсан юм.

Хайртай хүүхдүүдээ авар. Тэднийг зовоож, үхэлд хүргэх ямарваа нэг зүйл хийх шаардлагагүйг олон тохиолдлоос та бүхэн харж байна. Америкт хөвч хөндөлтийн дараах үр дагавраас болж жил бүр хамгийн багадаа 100 нях хүүхэд амь насаа алддаг гэсэн мэдээлэл бий. Энэ тоо илүү

олон байх магадлалтай, зарим эцэг, эх мэдээлдэггүй. Яагаад гэдгийг ойлгож байна. Тэд мэдээлэх тухай бодох ч сөхөөгүй дэндүү их зовж шаналж, энэ тухай ярихыг ч хүсдэггүй. Гэвч түүхээ сөхвөл тийм яргачин “бурханыг” шүтээд ямар ч сайн зүйлд хүрээгүйг мэдэх болно. Тэр нь Бурхан байх боломжгүй. Бурхан бол Хайр. Бурхан бол хайр энэрэлтэй, асрал халамжтай, энэрэл нигүүлсэл, өрөвч нинжин Нэгэн. Тэрээр хүүхдүүдээ, хүмүүсийг Өөрийнхөө дүрээр бүтээсэн. Хүүхдүүдээ зовоосой гэж Бурхан хүснэ гэж үү? Утга учиргүй байгаа биз дээ. Та бүхэн ухаантай, ойлгож байгаа. Тиймээс эргээд хар. Эргэн тойрноо хар, тийм яргачин чөтгөрийг шүтээд ямар ч сайн зүйл болоогүй. Эцэс төгсгөлгүй дайн дажин өдөөгдөж, хүмүүс үй олноороо зовж, гэмгүй хүүхэд нялхас амь үрэгдэж байна. Хэдэн арван жилийн өмнөх нэг явдлыг та бүхэн санаж байгаа байх. Холокоуст юу болсныг мэднэ. Гүйж байна, үүнийгээ зогсоо. Хүүхэд нялхсаа, өөрсдийгөө болон найз нөхдийгөө тамлахаа боль. Сэр. Сэр, Сэр. Нялх үрсийг тань зовоодог тийм Бурхан байдаггүй. Нялх үр тань таны хувьд туйлын эрхэм гэдгийг Бурхан мэднэ. Бурхан та бүхний сэтгэл санаа болоод бие махбодыг тамлахыг хүсдэггүй, нялх үрсийг тань ч тамлахыг хүсдэггүй. Яах гэж? Тэр үр дагаврыг нь мэднэ, ядаж л аймшигтай өвддөг. Хуруугаа эсгэхэд л ямар их өвддөг

билээ. Тийм байхад нялх хүүхэд яаж тэсэх вэ? Нялхас яаж тэсэж чадах вэ? Та бүхнийг ямар нэг байдлаар эмзэглүүлэх зүйл хэлсэн бол уучлаарай, гэхдээ зүрх сэтгэл минь... яг шатаж буцалж байгаа мэт байна. Яг л... ямар нэг зүйл шатаж буцалж байгаа мэт мэдрэгдэх юм. Энэ нялхсыг бодохоор, тэднийг ямар ч өршөөлгүйгээр ийм зүйл туулж буйг төсөөлөхөөр дотор минь шатах юм. Төрөөд хэдхэн хонож байгаа нялх хүүхдүүд шүү дээ, Бурхан минь. Гүйж байна, үүнийгээ зогсоо! Үгүй бол Бурхан та нарыг шийтгэнэ. Чөтгөрүүд, зөвхөн чөтгөрүүд л улс гүрнийг тань сүльдүүлж доройтуулахыг хүсдэг гэдгийг харахгүй байна гэж үү? Эр хүйстэй нялхас, эрэгтэй хүүхдүүд, насанд хүрсэн эрчүүд бол бидний ирээдүй, ялангуяа нялх хүүхдүүд (би уншиж чадахгүй нь) ялангуяа эр хүйстэй нялхас, эрэгтэй хүүхдүүд. Тэд бол ирээдүйн номлогч, ирээдүйн ерөнхийлөгч, улс орноо хамгаалагчид. Тиймээс чөтгөрүүд тэднийг гэмтээж, хороохыг хүсдэг. Ингэж улс орныг тань сул дорой болгодог. Улс орноо хүчирхэгжүүлэх, нийгэмдээ, эх орондоо ажил хийх эрчүүд цөөрнө. Ойлгож байна уу? Би та нарт жинхэнэ үнэнийг хэлж байна. Би яах гэж ийм зүйл хийх юм бэ? Өөрийгөө эрсдэлд оруулж, та бүхнийг доромжлох гэж үү? Чөтгөрүүд хаа сайгүй байдаг. Тэд өөрсдийгөө хүн болгож хувиргаад их хүндтэй сайхан

харагдаж, өөрсдийгөө бурхан, гэгээнтнүүд гэж хэлнэ.

Соломоны түүхийг санаж байна уу. Тэр гурван жилийн хугацаагаар цөлөгдөхөд чөтгөрүүд хаан ширээг нь, улс эх орныг нь, гэрийг нь эзэгнэж олон жигшмээр, харгис үйл хийдэг бөгөөд ард иргэд нь энэ бүхнийг Соломон л хийж байна гэж боддог. Гэтэл үгүй. Соломон энэ гурван жилийн хугацаанд цөллөгт байж байгаад ирдэг. Тэгээд чөтгөрүүдийг хөөж гаргасан. Есүсийг цөлд бясалгаж байхад бас л чөтгөрүүд ирж, Түүнийг уруу татахыг хичээсэн. Түүнийг хахуульдаж, хэрэв Есүс Сатанд мэхийн ёсолбол тэр Түүнд дэлхийг бүхэлд нь бэлэг болгон өгье гэж амладаг. Тэгэхэд нь Есүс юу гэж хэлдэг билээ? “Чи ард минь ор” буюу алга бол гэдэг. Буддаг бас чөтгөрүүд уруу татахаар ирэхэд нь тэр бас л адилхан ингэсэн. Гэвч оюун бодлын эмзэг төлөвт, эсвэл гэнэн цайлган итгэл үнэмшлээрээ хэн нэгэн буруу сонссон байх, эсвэл орчуулга нь буруу байсан уу? Бурханы дуу хоолой байна гэж эндүүрсэн байх. Тиймээс Бурхан Нэрээ цэвэрлэж, өгсөн тушаалаа засаж залруулах гэж Элчээ илгээсэн. Тэр нь Бурханы тушаал ч байгаагүй. Ийнхүү Элч нар ирж, Бурхан ямар ч амьтны мах цус идэхийг хүсдэггүй гэж хэлсэн, тэр үр хүүхдүүдээ хохироохыг яахин хүсэх билээ? Бурхан амьтдад туйлын хайртай учраас тэднийг зовоосой гэж хүсдэггүй. Тийм байтлаа та нарын хүүхдүүд, нялх

үрсийг тань үхлийн аюултай эрсдэл туулуулж, зовоохыг хүснэ гэж үү. Бодоод үз, за юу?

Буруу орчуулга олон сая, олон тэрбум гэмгүй хүний аминд хүрсэн. Жишээлбэл Энэтхэгт эрт дээр үед Ригведагийн 10.18.7-д нөхөр нь өөд болсон бэлэвсэн эмэгтэйг үргэлжлүүлэн амьдрахыг зөвлөсөн байдаг. Агрэ гэсэн үг нь “үргэлжлүүл” гэсэн утгатай. Гэвч агрэ гэдэг үгийг буруугаар орчуулж, буруу хөрвүүлж агнэ (гал) болгосон. Үүнээс болоод дууллын утга ийм болсон: “Бэлэвсэн эмэгтэйчүүд ямар ч зовлонгүй, нулимс унагалгүй гоёж чимээд гал руу алхан ор”. Ингээд “үргэлжлүүлэн амьдар” гэсэн утга “гал руу алхан ор” болж хувирсан. Тэс өөр утгатай байсан. Үхэгсдийг шатаадаг галд олон эмэгтэйг хүчээр шатаасан. Нас барсан нөхрийн шатаахдаа эхнэрийн түүнтэй хамт шатаадаг. Эрт дээр үед олон бэлэвсэн эмэгтэйг агрэ гэдэг үгийн дагуу үргэлжлүүлэн амьдруулах биш эсрэгээр нь үхсэн нөхөртэй нь хамт галд шатааж. Энэ бол аймшиг. Атарваведа 18.3.1-д хамгийн ихээр иш татдаг Ведийн тарниудын нэг байдаг нь эмэгтэйчүүдийг өөд болсон нөхөртэй нь шатаахыг дэмжсэн агуулгатай: “Нөхрийнхөө ертөнцийг сонгож, Өө энэ эмэгтэй амьгүй болсон биеийн дэргэд хэвтэнэ. Эртний зан заншлаа үнэнчээр хадгалж буй нь энэ билээ. Эд баялаг, үр хүүхэд хайрлах болтугай.” гэсэн байдаг. Энд “Нөхрийнхөө ертөнцийг сонгож,” гэдэг

хэсгийг буруу орчуулсан. Үүнийг эхнэр нь өөд болсон нөхөртэйгөө нэгдэж, дараагийн ертөнцөд оч гэж зөвлөж буй мэт ойлгосон. Тиймээс нөхрийн цогцсыг шатаах үед эхнэрийг нь хамт амьдаар нь шатаадаг болжээ. 1829 оноос эхлэн өөд болсон нөхөртэй нь хамт эхнэрийг амьдаар нь шатаадаг заншлыг хуулиар хориглосон. Гэсэн ч зарим Хиндү шашинтнууд эмэгтэй хүний хамгийн дээд золиослол, үнэнч сэтгэл гэж үздэг учраас хааяа ийм зүйл хийсээр л байна.

Үүнээс та бүхэн буруу орчуулга хийснээс үүдэн гэмгүй хүмүүсийн амийг аймшигтайгаар хороодог байсныг харж байна. Юунд итгэж, юуг дагаж байгаагаа бид бодож тунгааж байх учиртай, яагаад гэвэл Бурханы тааллыг дагахыг хүсэхдээ бид логик, учир шалтгааныг сонсох ёстой. Жишээлбэл Вед-д үүний эсрэг утгатай нэгэн тунхаглал бий. Атарваведа 18.3.2-т: “Босогтун, Өө эмэгтэй, амьгүй түүний дэргэд бүү хэвт, босоод амьдралын ертөнцөд морил.” гэж бичсэн байдаг. Энэ тарнид өөд болсон нөхрийнхөө дэргэд хэвтэх эмэгтэйг босоод амьдралаа үргэлжлүүл гэж хэлсэн байна. Мөн Вед-д бэлэвсэн эмэгтэйн дахин гэрлэлтийн тухай гардаг. Тэгэхээр энэ буруу орчуулга гэмгүй олон хүний амийг егүүтгэжээ. Би ийм утгаар л хэлэх гэсэн юм. Хүмүүс буруу сонсох юм уу, буруу орчуулсан байх. Тиймээс нялх үрсээ,

хүүхдүүдээ, эрэгтэйчүүдээ авар. Тэд амьдраг. Бүрэн бүтэн, эрүүл саруул, энх тунх байг. Бурхан тэднийг төгс бүтээсэн. Бид түүнийг хүчирхийлж, биеийнх нь аль нэг хэсгийг тайрч огтолж болохгүй. Ингэх нь Бурханы тааллын эсрэг явдал болно.

Тиймээс өөрийнхөө төлөө, эрүүл саруул ухаан, ёс суртахуун, нэр төрийн төлөө одоо цорын ганц шийдлийг хэрэгжүүлж ВЕГАН ХУУЛИЙГ БАТАЛ. ГЭМ ЗЭМГҮЙ ХҮН, АМЬТДЫГ АХИН БҮҮ ХӨНӨӨ. Дашрамд хэлэхэд энэ гарагийн бүх иргэн, бас амьтдыг дахин зовоохгүйн тулд Засгийн газартаа ВЕГАН ХУУЛЬ БАТЛАХАД нь дэмжлэг үзүүлээрэй. Үр хүүхдүүдээ хамгаалаарай. Бурхан тэднийг өвтгөхийг хүсдэггүй. Тэднийг өсөж том болоод сайн номлогч, сайн лам, сайн ерөнхийлөгч, сайн удирдагч, улс орон, гэр бүлээ авч явах хүчирхэг нэгэн болог гэж хайрлаж, хамгаалахыг хүсдэг. Жинхэнэ Бурхан ийм л байдаг. Миний мэдэх Бурхан ийм байдаг. Бүхнийг уучлагч. Гэмээ наманчлаад л та өршөөгдөх болно. Би амлаж байна, өөрт байгаа өчүүхэн нэр төрөөрөө амлая. Надад итгээрэй гэж гуйж байна. Бурхан бүхэлдээ хайр, уучлал. Зүгээр л буцаад зөв зүйл хий. Гэмээ наманчил. Бурхан та бүхнийг 100 хувь уучлах болно. Жинхэнэ Бурхан тийм байдаг, та нарыг сайн сайхан байлгахад машид анхааран Диваажинг та нарт хүлээцтэй хандахад

хүргэдэг. Амьтны мах идэж, цусыг нь ууж, нялхас хүүхдүүдийг гэмтээхийг хүсдэг Бурхан байх боломжгүй. Ялангуяа улс орон, гэр бүлээ хамгаалах, хүч чадалтай эрсийг шүү. Хүч тэнхээ, эр зориг, идеализм шаардлагатай үед бид эрчүүдэд найддаг. Тиймээс бид ямар ч эрэгтэй нялхсыг, эрэгтэй хүүхдийг, эрчүүдээ гэмтээж болохгүй. Тэд бидэнд хэрэгтэй. Эмэгтэйчүүдийг хүчирхийлдэг өөр зарим харгис зан заншил, уламжлал хаа нэгтээ бас байсаар байдаг, нөхцөл байдал нь төстэй. Эмэгтэйчүүдэд бас үүнтэй төстэй зан үйл үйлдэж, зовоож, цус алдуулж, халдвар авхуулж, үхүүлдэг. Ихэвчлэн өвчин намдаагчгүйгээр авдаг. Төсөөлж байна уу? Та өөрөө тийм байдалд орж байна гэж төсөөлөөд үз дээ? Ямар ч сонголтгүй тийм зүйлийг хийлгэж, өвдөж шанална.

Энэ бүхнийг зогсоо. Ухаалаг Засгийн газрууд энэ бүх балмад мухар сүсгийг зогсоох ёстой, эрх мэдэл нь бий. Энэ бүхнийг зогсоох хангалттай боловсрол, хангалттай эрх мэдэл та бүхэнд бий. Ингэхгүй бол Бурхан биднийг уучлахгүй, үүрд тэвчиж чадахгүй. Бусад нутаг нэгт нөхдөө гэмтээж хохироож байгааг хараад Бурхан цаг үргэлж тэвчиж чадахгүй. Гэхдээ бид энэ бүхнийг зогсоож, нүглээ наманчилбал Бурхан биднийг шууд уучилж мартана, бид ч элбэг хангалуун, аз жаргалтай амьдарч байгаад энэ

дэлхийг орхин одох үедээ Диваажин луу явах болно. Би амлая. Диваажин миний гэрч болог, Бурхан миний гэрч. Гараг дэлхий аврагдаж магадгүй ч ухамсарласнаа үл тоон амьтдын амийг таслах гэх мэтээр гэмгүй төрөлтнүүдийн зовлонгоор амьдардаг хэн бүхэн шүүлтээс мултрахгүй. Тиймээс хайр энэрэлт төрөлх мөн чанараа дагагтун. Дэлхийн улс орнуудын төр засаг, дэлхийн иргэд та бүхэн эх дэлхийгээ аз жаргалтай амьдралын орчин болгохын төлөө, үр хүүхдүүддээ илүү сайхан гараг дэлхийг үлдээхийн төлөө хамтран ажиллагтун. Бурхан та бүхэнтэй хамт байг. ВЕГАН ХУУЛЬ гаргах шийдвэрийг Бурхан ивээг. Бурханы ажлыг хийхдээ зоригтой бай, баатарлаг бай, шударга, ариун байж, айхыг март. Төрийн тэргүүн, Засгийн газрууд, энэ дэлхийн иргэд та бүхэн гэмгүй амьтдыг, нялх хүүхдүүдийг болон өөртэйгөө адил хүмүүсийг хөнөөхөө зогсооно уу. Диваажин та бүхэнд тусална. ВЕГАН ХУУЛЬ ГАРГААД ГАРЫН ҮСЭГ ЗУРЧИХ, түүнийгээ заавал хэрэгжүүлээрэй. Бүх Засгийн газар, төрийн тэргүүн, дэлхийн иргэдийн хувьд ЭНЭ НЬ ХАМГИЙН ЗӨВ ҮЙЛДЭЛ. Эх дэлхий маань энх тунх оршин тогтноосой гэвэл, ТАМЫН ГАЛЫН ШИЙТГЭЛЭЭС ХЭЛТРЭХИЙГ ХҮСЭЖ БАЙВАЛ эн тэргүүнд тавих ёстой зүйл нь энэ л байна. Бүгдэд тань баярлалаа. Энэ дэлхийн төрөлтнүүд та бүгдэд талархаж байна. Ахин хэлэхэд,

ЗӨВ ЗҮЙЛИЙГ Л ХИЙЧИХ. ВЕГАН ХУУЛЬ ГАРГААД ГАРЫН
ҮСЭГ ЗУРЧИХ. Тэгээд үүнийгээ чандлан хэрэгжүүлээрэй.
Веган бай. ЭНЭ БОЛ ХАМГИЙН ЗӨВ ЗАМ. Ийм байхад
л болчихно. Бусад бүх зүйл аяндаа байр байрандаа
орно. Хэрэв та бүхэн үүнийг хийж чадвал дэлхий
даяарт өгөөмөр нинжин сэтгэл, өршөөл ивээл, энэрэл
нигүүлсэл, аз жаргал түгэх болно. Дахин талархлаа
илэрхийлье. Та нар бүгдийг нь ойлгосон. Гуйж байна,
ВЕГАН ХУУЛЬ болон ВЕГАН АМЬДРАЛЫН ХЭВ МАЯГ. Энэ
цорын ганц зөв шударга үйлийг үйлдэгтүн. Баярлалаа.
Бурхан дэлхийг маань адисалж байх болтугай. Бурхан
бид бүхэнтэй үргэлж хамт байг.²¹

8 Их Багшийн илгээсэн урмын үгс

Веган хоолны дэглэм дэлхийд, бидний эргэн тойронд ариун, хамгаалагч, хайр энэрлийн үүр амьсгалыг бүрдүүлж, тэр эрч хүч биднийг хамгаалж байдаг. Үүнийг бид нотолж чадахгүй ч гэлээ тун логиктой. Бидний хийсэн үйл бүхэн бидэнд нөлөөлдөг. Тиймээс веган болсноор амьтдад нигүүлсэнгүй ханддаг болно, дээрээс нь веган болж гараг дэлхийгээ аврахад хувь нэмрээ оруулахыг үргэлж хүсч явбал бүр илүү их нигүүлслийг тээнэ, яагаад гэвэл бид гараг дэлхийгээ аврах том зорилгыг мөрөөдөж байна.

Энэ гараг дээр хүмүүс, амьтдыг оролцуулаад хэчнээн олон тэрбум, их наяд төрөлтөн байна вэ? Тийм учраас ийм бодол толгойдоо тээсэн бид маш нигүүлсэнгүй, нигүүлсэнгүй учраас таны орчин тойрны энерги хүчтэй, бүх төрөлтнүүдэд гүн гүнзгий нинжин сэтгэлээр хандана. Хэрвээ энэ дэлхий дээр байгаа хүн нэг бүрийн эргэн тойрон ийм их нинжин эрч хүчээр хүрээлэгдвэл дэлхий буцаад Диваажин болно. Аврагдаад зогсохгүй, одоогийнхоос хавьгүй дээрдэж, улам үзэсгэлэнтэй, улам

элбэг хангалуун болж, бүхний хүсэл биелэх болно.

Бурхан минь, миний юу ярьж байгааг хүн бүхэн ойлгоосой гэж маш их хүсэж байна. Баярлалаа. Эрч хүчийг бид барьж нотолж чадахгүй ч бид түүнийг мэдэрдэг. Жишээлбэл, таныг хамаг бүхнээ хуваалцдаг хайр энэрэлт найзтайгаа нэг өдөр маргалдсан гэж бодъё. Тэр өдөр хэдийгээр та хоёр хоорондоо ярихгүй байсан ч, эсвэл нэг нэгэн лүүгээ ном шидэхдээ хүрээгүй ч танд үнэхээр хүнд хэцүү мэдрэмж төрнө, яагаад гэвэл айл гэрийн энерги тань амар тайван бус, хайр үгүй, эв нэгдэлгүй мэдрэмж төрүүлнэ.

Хэдийгээр бид нотлох боломжгүй ч, энерги үнэхээр байдаг. Магадгүй одоо нотлох боломжтой болсон байж ч магад, эрдэмтэд хүний энергийн талаар олон нээлт хийсэн. Хэн нэгэн хүн уурласан үед энерги нь дордож байгаа нь мэдрэгддэг. Харин аз жаргалтай байх үед энерги нь илүү энэрэнгүй, эерэг, ач тустай байгааг мэдэрнэ.

Тэгэхээр амьтдыг хайрлан дэлхийг аврахыг хүссэнээс үүсэх энерги нь асар хүчтэй, танд болон таны эргэн тойронд байгаа бүх хүнд нөлөөлнө. Логик талаас нь харвал веган хоолны дэглэм бидэнд хэрэгтэй тэр

хамгаалалтыг үүсгэнэ. Бидэнд ийм хамгаалагч хүч хэрэгтэй.²²

Хайраа том байлгаарай, Том, Том, Том Том байх тусмаа сайн! Эргэн тойронд байгаа бүхнээ хайрла.

Бидэнд алдах зүйл байхгүй. Үхсэн амьтдын цогцсыг тавган дээрээсээ халж, оронд нь амттай, эрүүл, ургамлын, амттай төрөл бүрийн уургийг хэрэглэ. Веган байж, энх амгаланг бүтээ. Бидний хийх зүйл ердөө л энэ, бас хайрлаарай. Хүссэнээрээ их хайрла, харин бүү дайн өдөө. Та бүхэнд маш их баярлалаа. Бурхан бид бүгдийг адислах болтугай.²

Бид бол энэрэл нигүүлсэл. Бид өршөөл энэрэлтэй, хайр асралтай төрөлтнүүд. Бид ердөө л хууртчихсан. Өдийг хүртэл бидэнд худал мэдээлэл өгч байж, түүнийг нь мэдээгүй байсан аж. Дэлхий даяараа веган болох тэр үед энэрэл нигүүлсэл хүчээ авч, бүхий л соёл уламжлал нэгдэн хамтдаа хөгжиж, хүн төрөлтөн, амьтад амар амгалан болно.

Аллага үйлдэхийн эсрэг бүхий л амьдралыг хүндлэхийг сонгосон тэр цагт дотоодын тэр их амар амгалан дэлхийгээр яг л далайн давлагаа мэт түгж, хүмүүсийн зүрх сэтгэлийг дэвшүүлэн Дэлхий дээр эв зохиорлой Диваажинг цогцлооно. Энэ нь бид бүхнийг мөнхийн

Алтан Эринд авчирна.¹⁹

Будда бидний мөн чанарыг хайр, нигүүлсэл гэж сургасан. Гэвч бид өөрсдийн үл тоомсорлох зангаасаа болж төрлөөс төрөл рүү шилжихдээ буруу замаар яван энэ оршихуйн хар бараан хүчинд дарамтлуулж, улам бүр мартжээ. Тиймээс хүмүүсийг өөрсдийгөө хайрлахаа, амьтдыг хайрлахаа мартсаныг нь, эсвэл өөрсдийгөө үнэхээр хайр гэдгээ мартсаныг нь би хэзээ ч буруутгаж байгаагүй.

Хүмүүс хайрын бүрэлбаа юм. Үүнийгээ дахин санах цаг нь болсон, үгүй бол бид өөрсдийнхөө гараар өөрсдийгөө мөхөлд хүргэх нь. Амьтдыг хайрлаж эхлэх нэг зам бол тэдний юу үзэж туулдгийг ойлгох явдал юм. Нядалгааны газарт очоод хар, хонь, ямаа, адуу, тахиа, гахайг алж байгааг хар, эсвэл зурагтаар, бичлэгээр үзэж, гоёмсгоор савласан зүсэм махны цаана юу болдгийг, жинхэнэ аймшиг, айдас, шаналал гэж юу байдгийг мэдэж ав. Хэрвээ хүн тэр амьтдын мэдэрдэг тэр тамын шиг айдсыг мэддэг сэн бол, бодит үнэнийг мэдчихвэл, тэр үмх махыг хоолойгоороо давуулахад тун ч хэцүү болно.

Хүн хайрын чанараа яаж нэмэгдүүлэх вэ гэж та нар асуусан. Би үүнийг LQ гэж нэрлэдэг. Хүмүүс бидэнд IQ, LQ гээд олон Q (чанар) бий.

GQ (Бурхан чанар) гэж ч бий. Хүн, амьтдын аль алинд нь ийм Хайрын Чанар (LQ) байдаг. Азаар хүмүүс бидэнд давуу тал бий. Тэр нь юу вэ гэвэл бид хайрыг яг л булчин шөрмөс шигээ хөгжүүлэн Хайрын Чанараа нэмэгдүүлэх боломжтой байдаг явдал. Амьдралын хэв маягаа огт өөрчлөхгүйгээр өглөө, өдөр, оройн хоолон дээрээ л ямар ч дасгал хийлгүйгээр хайрын булчингаа хөгжүүлэх боломжтой.

Гэр бүлийнхэн, гэрийн тэжээвэр амьтад, найз нөхөд, дайснуудаа нэг адил хайрлахын тулд веган байж, тэр хайраа дэлхий дээр бидэнтэй зэрэгцэн орших бүхий л төрөлтнөөр тэлэн өргөжүүл. Ургамал, мод, цэцэг, хайрга чулууг ч мөн адил хайрлаарай. Зөвхөн веган болсны дараа, шууд л хэдхэн өдрийн дараа, эсвэл хэдхэн долоо хоногийн дараа дотоодод тань ямар нэг зүйл өөрчлөгдөхийг мэдрэх болно. Таны өөрийн хайрын чанар булаг мэт аяндаа л урсана, хайрын булаг мэт. Нар, сар, оддоос, байгалиас, бидэнтэй зэрэгцэн орших төрөлтнүүдийн хайр, адислалыг улам ихээр хүлээн авна. Гэнэт л амьтад үнэнхүү үзэсгэлэнтэй, нөхөрсөг, ухаалаг, хайр хүрэм найзууд, хөршүүд юм байна гэдэг нь харагдах болно.

Тэднийг шууд л хайрлаж, тэдэнд ямар нэгэн байдлаар

зовлон учруулах, өвтгөх, бүр шууд бус утгаар ч зовж тарчилсан махыг нь идэх тухай төсөөлөхөд ч хэцүү болно.²³

9 Веган Дэлхийн төлөө залбираарай

Хамтдаа залбиръя. Хэдийгээр та одоо веган болж чадаагүй байгаа ч, удахгүй тийм больё гэж даатган залбираарай. Веган дэлхийн төлөө залбир. Өдөр бүр Хонконгийн цагаар оройн 21:00 – 22:00 цагийн хооронд бидэнтэй нэгдэн Веган Дэлхийн төлөө залбирч, бас бясалгаарай. Веган Дэлхий биеллээ олбол үүрдийн энх амгалан тогтоно. Диваажин та бүгдийг арвин ихээр адислах болтугай. Та бүхэнд маш их баярлалаа.

Бидний залбирал нэн хүчтэй, яагаад гэвэл түүний ард Диваажингууд, Гэгээнтнүүд, Бурханы Хүч байдаг. Урьд хожид мэдэгдэж байгаагүй тийм хүчтэй болно, ялангуяа бид одоо хамтдаа залбирч байгаа учраас үнэхээр хүчирхэг. Та веган болж, веган болохын төлөө залбирч, удахгүй веган болно хэмээн залбирч, хамаг л энэрэл нигүүлсэхүй чанараараа залбирч байгаа учраас асар их үр дүнтэй. Гэр бүлийнхээ гишүүд, найз нөхөд, таньж мэддэг хүмүүстээ бидэнтэй нэгдэн веган дэлхийн төлөө залбиръя гэж уриалаарай. Энэ нь тэдэнд ч бас хэрэгтэй.

Хамтдаа нэг цаг орчим залбиран бясалгаж, Дэлхий Веган болох тэр өдрийг хүртэл өдөр бүр үргэлжлүүлээрэй.

Чин сэтгэлээр таван минут, хорин минут бясалгавал энэ бүхэн дэлхийг ариусгаж, үр хүүхдүүдийг минь аварч, бид бүгдээрээ эрхэм ариун, үнэ цэнтэй, ёс журамтай, Бурханы зүй ёсны хүүхдүүд байх болно. Гэм зэмгүй хөөрхий төрөлтнүүдийг аврах үйлсэд маань нэгдээрэй. Эх дэлхийгээ аврах үйлсэд нэгдээрэй. Гуйж байна! Бурхан та бүгдийг энэ төрөл, дараагийн төрөлд тань арвин ихээр адислах болтугай.



**Байгаа газраа сэрүүлэг тавиад, юу ч хийж байсан
түр зогсоогоод бидэнтэй хамт Веган Дэлхийн төлөө
залбираарай, Хонконгийн цагаар**

21:00 - 22:00

цагийн хооронд.²⁴



Эшлэл

Оршил

1. Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай байгаль орчны талаар: Эрхэм ариунд зорьж, зүрх сэтгэлээ өөрчилбөл дэлхийг аврах боломжтой, 2008 оны 7 сарын 20-нд Ау Лак (Вьетнам) дахь нийгэмлэгийн гишүүдтэй хийсэн видеоконференц. Video 839.

<http://video.godsdirectcontact.net/daily/2008.09.26/BMD743.wmv>

2. “Жинхэнэ Хайр” – Зүрх сэтгэлийг нэгтгэгч дуу аялгуу 2011 оны 8 сарын 27-нд АНУ-ын Калифорни мужид хийсэн телеконференц, DVD 999.

<https://suprememastertv.com/mn1/v/136665388570.html>

1-р бүлэг

3. Сэрэхтүн, цэвэрлэгээний энэ цаг үед веган болохтун. 2020 оны 6 сарын 26-нд Суприм Мастер Телевизийн ажлын багийнхантай хийсэн конференц.

<https://suprememastertv.com/mn1/v/102385733924.html>

4. Сэрэхтүн, цэвэрлэгээний энэ цаг үед веган болохтун. 2020 оны 6 сарын 26-нд Суприм Мастер Телевизийн ажлын багийнхантай хийсэн конференц.

<https://suprememastertv.com/mn1/v/131957486562.html>

2-р бүлэг

5. Хүн төрөлхтөн Алтан Эринд үсрэн шилжихүй, 2009 оны 11 сарын 8-нд АНУ-ын Вашингтон ДС хотноо болсон Олон улсын конференц.

<https://suprememastertv.com/mn1/v/131957486562.html>

3-р бүлэг

6. Бурханыг хайрлахын тулд Түүний Сахилыг сахихтун, 1989 оны 11 сарын 29-нд Панамад айлдсан лекц DVD 106.

http://www.suprememastertv.tv/bbs/board.php?bo_table=download&wr_id=8423&goto_url=&sfl=wr_content&stx=To+Keep+Hiers+Commandments&sst=wr_num&sop=and&url=link2&year=&month=&day=

Агшин зуур билиг нээгдэхийн түлхүүр 3-р дэвтэр, 104-106-р хуудас .

<http://www.smchbooks.com/ebook/data/english/E-The%20Key-E3.pdf>

7. Дэлхийн эв нэгдэл: Хамтдаа амь аврахуй, 2009 оны 10 сарын 3-нд Хонг Конгт хийсэн олон улсын конференц DVD 882-1.

<http://video.godsdirectcontact.net/daily/2009.11.22/WOW1165.wmv>

8. Бурханы гэрэлт бамбарыг тээгч бай 1999 оны 11 сарын 25-нд Өмнө Африкийн Иоханнэсбург хотноо олон нийтэд айлдсан лекц, DVD 667.

<https://suprememastertv.com/mn1/v/99665258964.html>

4-р бүлэг

9. 2009 оны 12 сарын 16-нд Ирландын Нохойн тухай сэтгүүлээс Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайтай хийсэн ярилцлага, DVD 899.

<http://video.godsdirectcontact.net/daily/2010.03.24/WOW1287.wmv>

10. Хүүхдүүдийн эрүүл мэнд ба гараг дэлхийн тогтвортой байдал, 2009 оны 9 сарын 21-нд Өмнөд Солонгосын

Жежү арал дээр хийсэн олон улсын конференц,
DVD 881-3.

<http://video.godsdirectcontact.net/daily/2009.11.10/WOW1153.wmv>

11. Хайрын хуулийг мөрдөн ариун журамтай амьдрахуй,
2008 оны 7 сарын 31-нд АНУ-ын Лос Анжелес хот дахь
нийгэмлэгийн гишүүдтэй хийсэн видеоконференц,
DVD 842.

[http://video.godsdirectcontact.net/
download/2008.10.31/Between_Master_and_
Disciples_2008.10.31_778.wmv](http://video.godsdirectcontact.net/download/2008.10.31/Between_Master_and_Disciples_2008.10.31_778.wmv)

12. Өөрийгөө огоорсноор Амжилтад хүрч чадна,
1993 оны 3 сарын 7-нд Сингапурт хийсэн нийтийн
бясалгал, DVD 326.

13. Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн хэвлэлийнхэнд
өгсөн ярилцлага: Оюун санааны Сэхээрлийн
Радиоогийн Жэймс Бийн, Тогтвортой Байгаль
Радиоогийн Боб Лэбэнсолд, Айриш Индэпэндэнт
сонины хатагтай Андриа Бонни, АНУ болон Ирландын
хэвлэлүүдэд 2008 оны 7 сарын 29, 9 сарын 11 болон 11
сарын 21-нд өгсөн ярилцлага, DVD 854-1.

[http://video.godsdirectcontact.net/
download/2008.09.28/Words_of_
Wisdom_2008.09.28_745.wmv](http://video.godsdirectcontact.net/download/2008.09.28/Words_of_Wisdom_2008.09.28_745.wmv)

14. Веган Дэлхий Мөнхийн амар амгаланг цогцлооно,
2020 оны 12 сарын 24-нд Суприм Мастер Телевизийн
ажлын багийнхантай хийсэн видео конференц.
[https://suprememastertv.com/mn1/v/118282097128.
html](https://suprememastertv.com/mn1/v/118282097128.html)

5-р бүлэг

15. Хаан эргэж ирсэн нь.

[https://suprememastertv.com/mn1/v/126653410185.](https://suprememastertv.com/mn1/v/126653410185)

html

Энх тайван биднээс эхлэг, 1989 оны 10 сарын 1-нд
Малайз Улсад айлдсан лекц, DVD 99.

16. Өөрийгөө бясалгалаараа адисла: Төгс Гэгээрсэн Их
Багш Чин Хайн “Амьдралаа өнгөлөг болгохуй”
номын хэсгээс.

[https://suprememastertv.com/mn1/v/129254659480.](https://suprememastertv.com/mn1/v/129254659480)

html

17. Бясалгал таныг хамгаална, 2020 оны 9 сарын 2-нд
Суприм Мастер Телевизийн ажлын багийнхантай
хийсэн конференц.

[https://suprememastertv.com/mn1/v/111118523935.](https://suprememastertv.com/mn1/v/111118523935)

html

18. Арьяабалын Аргын Бясалгал – Дотоодын Гэрэл,
Аялгууны Бясалгал.

<https://suprememastertv.com/mn1/meditation/>

19. Хүн төрөлхтөн Алтан Эринд үсрэн шилжихүй,
2009 оны 11 сарын 8-нд АНУ-ын Вашингтон ДС хотноо
болсон Олон улсын видеоконференц, DVD 818-2.

[https://suprememastertv.com/mn1/v/132161236579.](https://suprememastertv.com/mn1/v/132161236579)

html

6-р бүлэг

20. Бүх шашны болон оюун санааны удирдагч нарт

хүргэх Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн захидал, 2020 оны 3 сарын 2-ны видео мессеж.
<https://suprememastertv.com/mn1/v/88425789933.html>

7-р бүлэг

21. Дэлхийн бүх улс орны төр засгийн удирдагч, засгийн газарт яаралтай хүргэх Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн захидал, 2020 оны 3 сарын 24-ний видео мессеж:
<https://suprememastertv.com/mn1/v/90753335579.html>

8-р бүлэг

22. Тэнгэрлэг урлаг, 2008 оны 12 сарын 12-нд АНУ-ын Лос Анжелес хотноо болсон олон улсын номын нээлт, англи хэлээрх хэвлэл, DVD 852-2.
<http://video.suprememastertv.com/daily/2009.01.14/WOW853.wmv>

23. Эрин зууны хайр, 2011 оны 4 сарын 22-нд Монгол Улсын Улаанбаатар хотноо болсон олон улсын номын нээлт, монгол хэлээрх хэвлэл, DVD 950-1.
<http://video.suprememastertv.com/daily/2011.06.01/WOW1721.wmv>

9-р бүлэг

24. Эх дэлхийгээ аврахын төлөө Веган Дэлхийн төлөө залбирахыг Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай уриалж байна, 2020 оны 2 сарын 6-ны видео мессеж.
<https://suprememastertv.com/mn1/v/85783840493.html>



Зохиогч: Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай

Хэвлэсэн: Love Ocean Creative Олон улсын компани
Шуудангийн Хайрцаг 109-973 ТАЙПЕЙ, ТАЙПЕЙ ХОТ,

11099 Тайвань (R.O.C)

Утас: 886-2-87896317

И-мэйл: service@loveoceancreative.com

<http://www.smchbooks.com>

Цахим номны эхний хувилбар: 2023 оны 3 сар

ISBN: 979-8-9866563-4-2

Love Ocean Creative олон улсын компани©2021

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай©2021

Бүх эрх хуулиар хамгаалагдсан.

Дэлгэрэнгүй мэдээллийг
дараах хаягаас авна уу
www.SupremeMasterTV.com

“Хайр цорын ганц шийдэл нь” хэмээх энэ номд олон улсын шилдэг борлуулалттай номын зохиогч, оюун санааны Их Багш, хүмүүнлэг үйлстэн, уран бүтээлч Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай цар тахал, уур амьсгалын өөрчлөлт, зөрчил тэмцэл, байгалийн гамшиг гэх мэт дэлхийн өнөөгийн нөхцөл байдлын талаар тайлбарлаж, энэ бүхний шалтгаан, бас шийдлийг нь хэлж өгсөн билээ.

Амьтдыг, байгалийг хайрлаж, нэг нэгнээ, гэр бүлээ, дайснаа хүртэл хайрласнаар бид Дэлхийд Диваажинг цогцлоох боломжтой. ХАЙРЫН энерги нь дэлхийг анагааж, хамгаалах үр нөлөөтэйгөөс гадна оршин суугчдыг нь илүү өндөр дээд ухамсрын төвшинд дэвшүүлэх болно. Тэрээр цааш нь сул дорой, дуу хоолойгүй амьтдыг болон ядарсан хүмүүсийг хамгаалахыг тулд бид бүхнийг хайраа үйл хэрэг болгохыг уриалсан билээ.

“Хайр цэцэглэн тэлэх юм уу, устаж үгүй болох боломжтой. Харин хайрын мөн чанарыг хэзээ ч устгах боломжгүй. Хайрыг тэтгэж тэлэх үйлс байдаг бол хагдруулж үхүүлэх үйлс ч байдаг. Материаллаг хайрыг хэлж байгаа юм шүү. Энэ оршихуйн хайрыг хэлж буй юм. Хайрыг өсгөн тэлэх үйлс ч байдаг, хумьж багасгах ч үйлс бий. Хэрэв бид хайрыг олбол эрхэмлэж, нандигнах хэрэгтэй. Үүнийгээ дэмжих хэрэгтэй. Бодол санаа, үг хэл, үйл хөдлөлөөрөө дэмжих хэрэгтэй.”

~ Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай

